



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО 56.7 ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН
ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРЫН БОДЛОГЫН БИЕЛЭЛТ 53.7 ХУВЬТАЙ
ГАРЧ ЗОРИЛТОТ ҮР ДҮН ХАНГАГДААГҮЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ
2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

АУДИТЫН КОД: АГГ-2021/07-ШТА-ГА



Улаанбаатар хот
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор

Д.Энхболд

Утас: 263755 Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер **Н.Анхбаяр**

Утас: 261805 Цахим хаяг: ankhbayarn@audit.gov.mn

Ахлах аудитор М.Наранжаргал

Утас: 262456 Цахим хаяг: naranjargalm@audit.gov.mn

Аудитор М.Өлзиймягмар

Утас: 261456 Цахим хаяг: ulziimyagmarm@audit.gov.mn

Аудитор С.Сугармаа

Утас: 261456 Цахим хаяг: sugarmaas@audit.gov.mn

Аудитор Ч.Бумдарь

Утас: 261456 Цахим хаяг: bumdarich@audit.gov.mn

Аудитор Д.Эрдэнэтуяа

Утас: 261456 Цахим хаяг: erdenetuyad@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.1.10, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.


2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Эдийн засгийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга /Ц.Нямдорж/, Сангийн сайд /Б.Жавхлан/, Төсвийн ерөнхийлөн захирагчид, Үндэсний хөгжлийн газрын дарга /Х.Батжаргал/ нарт тус тус зөвлөсүгэй.

4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор /Ц.Наранчимэг/-т даалгасугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын багт үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ



Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

Төлбөр, зөрчлийн товч утга	№	Мөнгөн дүн (тэрбум төгрөг)	Зөрчил хариуцах	
		Албан шаардлага	Байгууллага	Албан тушаалтан
"Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн төсөлд холбогдох ТЕЗ-аас зорилт, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн дүнг ам.доллараар хүргүүлсэн нь холбогдох хуулийн заалттай нийцээгүй байна.	1	8,580.7	УУХҮЯ	сайд
	2	8,344.5	ЗТХЯ	сайд
	3	1,233.1	ЭХЯ	сайд
	4	811.4	БХБЯ	сайд
Нийт дүн		18,969.7		

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ	3
ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ	4
ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ	4
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ	5
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6-8

БҮЛЭГ 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Макро эдийн засгийн бодлогын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлэх, эдийн засгийн тогтвортой орчныг хангахад чиглэсэн зорилтын хэрэгжилт бүрэн хангагдаагүй, биелэлт 56.7 хувь байна.	10-12
Макро эдийн засгийн бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилт нь хэрэгжүүлэгч байгууллагын зохион байгуулалт хангалтгүй, “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр зорилтот үр дүнд хүрээгүй, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийхгүй байгаагаас удаашралтай байна.	12-15
Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлогын зарим арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүйн улмаас зорилтот үр дүнд хангахуйцаар хэрэгжүүлээгүй, биелэлт 53.7 хувь байна.	16-17
Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлогын зарим арга хэмжээний хөрөнгө батлагдаагүй, удирдлага зохион байгуулалт, хяналт хангалтгүйгээс үр дүнд хүрээгүй байна.	18-23

БҮЛЭГ 2. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОН ЗАСАГЛАЛ, ЭРХЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ 82.5 ХУВЬ БАЙНА.

Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын зарим зорилт, арга хэмжээний санхүүжилт батлагдаагүйгээс хугацаандаа бүрэн хэрэгжээгүй байна.	25
Бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тоо баримт, судалгаа шинжилгээнд үндэслэн үнэлж, дүгнээгүй, үнэн зөв, бүрэн тайлагнаагүй байна.	26
Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлогын арга хэмжээг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн холбогдох заалт, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний үзүүлэлттэй уялдуулан төлөвлөх асуудал хангалтгүй байна.	29
Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөөгүй, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусгаагүйгээс арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, зорилтод үр дүнд хүрээгүй байна.	30
Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогын арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүйгээс “Хил орчмын дэд бүтцийг хөгжүүлж, хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх” арга хэмжээ үр дүнгүй байна.	33
Салбарын бодлогын хүрээнд 3 арга хэмжээний төсөв санхүүжилт батлагдаагүйгээс зорилтот түвшинд хүрээгүй байна.	34

ДҮГНЭЛТ	35
ЗӨВЛӨМЖ	36
ЗГХЭГ-ААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР	37-38
ҮАГ-ЫН ТАЙЛБАР	39
САНГИЙН ЯАМНААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР	40-41
ҮАГ-ЫН ТАЙЛБАР	42
ХАВСРАЛТ	43-47

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
ТХМ	Төсвийн хүрээний мэдэгдэл
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
АДБООС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУТХҮБ	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГҮАХХАХТ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
ДМАЭМБ	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага

Хүснэгтийн товчлол

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д зарцуулсан хөрөнгийн нэгтгэл	6
Хүснэгт 2	“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилт, арга хэмжээний жилийн эцсийн биелэлт, бодлогын төрлөөр	7
Хүснэгт 3	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн нэгтгэл	7
Хүснэгт 4	Үндсэн чиглэлийн төсөлд төсөв захирагчдаас хүргүүлсэн санал, тусгагдаагүй арга хэмжээний нэгтгэл	9
Хүснэгт 5	“МУТХҮБ-2030” болон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн харьцуулалт	11
Хүснэгт 6	Макро эдийн засгийн бодлогын эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй арга хэмжээний нэгтгэл	12
Хүснэгт 7	ДНБ-ий өсөлт, бууралтад уул уурхай, уул уурхайн бус салбарын оролцоо	13
Хүснэгт 8	“Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны үзүүлэлт” /тэрбум төгрөг, хувь/	14
Хүснэгт 9	2019-2020 оны Засгийн газрын гадаад өр, гадаад валют, ДНБ-ий өсөлтийн харьцуулалт	14
Хүснэгт 10	Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлогын хэрэгжилт	16
Хүснэгт 11	“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд ХХААХҮЯ, УУХҮЯ, ЭХЯ, ЗТХЯ-с хүргүүлсэн санал, тусгагдаагүй арга хэмжээний нэгтгэл	16-17
Хүснэгт 12	ТЕЗ-ийн багцын 2020 оны төсвийн төсөлд тусгасан зарлагын дээд хязгаар, Үндсэн чиглэлийн төсөлд тусгуулах саналын дүнгийн харьцуулалт	17
Хүснэгт 13	Эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогын эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй арга хэмжээний нэгтгэл	18
Хүснэгт 14	Монгол мал үндэсний хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлт, 2020 оны гүйцэтгэлийн харьцуулалтын нэгтгэл	19
Хүснэгт 15	“Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого”-ын зорилт, арга хэмжээний нэгдсэн судалгаа	24
Хүснэгт 16	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын хэрэгжилт (зорилт тус бүрээр)	25
Хүснэгт 17	Зорилт, арга хэмжээний төлөвлөлтийн нэгдсэн судалгаа (тэрбум.төгрөг)	29
Хүснэгт 18	Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлогын эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй арга хэмжээний нэгтгэл	30
Хүснэгт 19	Зорилт, арга хэмжээний төлөвлөлтийн нэгдсэн судалгаа (тэрбум төгрөг)	33

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ҮАГ-аас Үндсэн чиглэлийн биелэлтийг 2017-2020 онд үнэлсэн нэгтгэл	7
Дүрслэл 2	ҮАГ-аас Үндсэн чиглэлийн салбаруудын биелэлтийг 2017-2020 онд үнэлсэн нэгтгэл	8
Дүрслэл 3	Макро эдийн засгийн бодлого нь урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөртэй уялдсан байдал	11
Дүрслэл 4	Эдийн засгийн өсөлт/хувиар/	12
Дүрслэл 5	"МУТХҮБ-2030"-д Урт хугацааны эдийн засгийн жилийн дундаж өсөлт, ДНБ-ий бодит өсөлт	13
Дүрслэл 6	Ажилгүйдлийн түвшин /сүүлийн 5 жилээр/	13
Дүрслэл 7	Инфляцын түвшин /сүүлийн 5 жилээр/	13
Дүрслэл 8	Монгол Улсын төсвийн үзүүлэлт /тэрбум төгрөг/	14
Дүрслэл 9	Монгол Улсын Засгийн газрын нийт өрийн судалгаа	14
Дүрслэл 10	"МУТХҮБ-2030"-д Засгийн газрын гадаад өр/ДНБ-ий эзлэх хувь, Засгийн газрын гадаад өр/ДНБ-ий эзлэх хувьд хүрсэн түвшин	15
Дүрслэл 11	Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогод урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөр тусгагдсан судалгаа	16
Дүрслэл 12	Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл	18
Дүрслэл 13	Малын тоо толгой төрлөөр	18
Дүрслэл 14	Мал,малын гаралтай бүтээгдэхүүний экспорт	19
Дүрслэл 15	Жимс,жимсгэнийн тариалалт	19
Дүрслэл 16	Монгол Улсын нийт экспортод боловсруулах үйлдвэрийн эзлэх хувийн жин	20
Дүрслэл 17	Боловсруулах үйлдвэрт арьс шир,ноос ноолуурын түүхий эдийн үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин	20
Дүрслэл 18	Эрчим хүчний хэрэглээ /2020 он/	21
Дүрслэл 19	Эрчим хүч үйлдвэрлэл /2020 он/	22
Дүрслэл 20	Шинээр ашиглалтад оруулсан зам /км/	22
Дүрслэл 21	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогод урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөр тусгагдсан судалгаа	24
Дүрслэл 22	Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлогод урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөр тусгагдсан судалгаа	29
Дүрслэл 23	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагчдын хамран сургалт	30
Дүрслэл 24	Ерөнхий боловсролын сургуулийн 3 ээлжээр хичээллэж буй байдал	31
Дүрслэл 25	Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид	31
Дүрслэл 26	Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогод урт, дунд хугацааны бодлогын баримт,бичиг, үндэсний хөтөлбөр тусгагдсан судалгаа	33

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний судалгаа	43
Хавсралт 2	Үр дүнгүй арга хэмжээний судалгаа	44
Хавсралт 3	Үндсэн чиглэлийн төсөлд Сангийн яамнаас нэмж тусгасан санал	45
Хавсралт 4	“Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай” хуулийн өөрчлөлтийн судалгаа	46
Хавсралт 5	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчин, Хүний хөгжил,нийгмийг хөгжүүлэх болон Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого бодлогын хэрэгжилт	46
Хавсралт 6	Үндсэн чиглэлд тусгагдсан урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй зорилт арга хэмжээ	47

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоол, Төсвийн байнгын хорооны 2020 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтуудын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Макро эдийн засгийн болон Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлого үр дүнтэй хэрэгжсэн эсэх;
- Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчин, Хүний хөгжил нийгмийг хөгжүүлэх болон Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах үүрэг хүлээсэн Төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлагуудын хяналт шинжилгээ үнэлгээний тайлан, холбогдох бусад байгууллагын баримт материалыг хамруулсан болно.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 3000-3100, Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журам, Гүйцэтгэлийн аудитад нотлох зүйлийг үнэлэх, дүн шинжилгээ хийх заавар, журмыг ашиглаж, шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас тайлбар тодруулга, судалгаа авах, шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын асуудлын шинжилгээ, арга зүй, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Н.Анхбаяр чанарын хяналтыг хэрэгжүүлж, Ахлах аудитор М.Наранжаргал, аудитор С.Сугармаа, Ч.Бумдарь, М.Өлзиймягмар, Д.Эрдэнэтуяа нар 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

Аудитын учирсан бэрхшээл:

явцад хүндрэл,

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийх гүйцэтгэлийн аудитын талбарын үе шатны ажил 2020 оны 2 дугаар сарын 24-нөөс 2020 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийгдэхээр төлөвлөгдсөн.

Дэлхий нийтэд коронавирус буюу титэмвирусны өвчлөл цар тахлын хэмжээнд хүрч Засгийн газраас тогтоосон хатуу хөл хорио, тодорхой хязгаарлалтын улмаас холбогдох яам, агентлаг дээр очиж ажиллах боломжгүй байдал үүссэн тул холбогдох баримт материалыг цахимаар авч, цахим мэдээллийн технологи нэвтрүүлэх бодлогын хүрээнд аудитыг цахимаар гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл /цаашид “Үндсэн чиглэл” гэх/-д батлагдсан нийт 127 зорилт, арга хэмжээнд агуулгын хувьд давхардсан тоогоор Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030¹-аас 77 арга хэмжээ, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс² 117 арга хэмжээ, үндэсний болон төрөөс баримтлах салбарын бодлогын баримт бичгээс 39 арга хэмжээ тус тус тусгагдсан байна.

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Төсвийн тухай хуулийн 12¹ дугаар зүйлийн 12^{1.1.1}-д³ заасны дагуу үндсэн чиглэлийн төслийн талаар урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн дүнтэй уялдаж байгаа эсэхэд санал, дүгнэлт өгөх чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Сангийн яам нь Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 50⁴-т заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй, холбогдох ТЕЗ, агентлагийн үндсэн чиглэлийн төсөлд хүргүүлсэн саналаас ямар санал нь тусгагдсан, тусгагдаагүй тухай үндэслэл, тайлбар хариуг хүргүүлээгүй байна.

Үндсэн чиглэлд улсын төсөв, гадаад эх үүсвэр, Хөгжлийн банк, ТХХТ, хувийн хөрөнгө оруулалт, Засгийн газрын тусгай сан, бусад эх үүсвэрээс шаардагдах нийт 11,022.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг баталж, гүйцэтгэлээр 5,404.0 тэрбум төгрөг буюу нийт төлөвлөсөн хөрөнгийн 49 хувь зарцуулагдсан байна. Үүнд:

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д зарцуулсан хөрөнгийн нэгтгэл

Хүснэгт 1.

№	Бодлогын нэр	Нийт зарцуулсан хөрөнгө	Зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр /тэрбум төгрөг/						
			Улсын төсөв	Гадаад эх үүсвэр	Хөгжлийн банк	ТХХТ	Хувийн хөрөнгө оруулалт	Засгийн газрын тусгай сан	бусад эх үүсвэр
1	Макро эдийн засгийн бодлого	-	-	-	-	-	-	-	-
2	Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	3,749.8	157.6	433.8	27.9	-	3,105.4	25.1	0.1
3	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	370.9	93.0	275.7	0.8	0.1	-	0.2	1.1
4	Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого	1,224.8	997.8	11.6	-	-	174.3	41.1	-
5	Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	58.6	44.9	0.9	-	-	-	5.2	7.5
2020 онд зарцуулсан хөрөнгийн нийт дүн		5,404.0	1,293.3	722.0	28.7	0.1	3,279.7	71.6	8.7

Эх сурвалж: УАГ

Үндсэн чиглэлд зарцуулсан хөрөнгийн 74.7 хувийг гадаад эх үүсвэр, хувийн хөрөнгө оруулалт, хөгжлийн банк, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

Үндсэн чиглэлийн биелэлтийг Сангийн яам 80.9 хувийн биелэлттэй гэж үзсэн бол ЗГХЭГ 75.9 хувь буюу үүнээс үр дүнтэй хэрэгжсэн 64, тодорхой үр дүнд хүрсэн 31, эрчимжүүлэх шаардлагатай 25, үр дүнгүй 7 арга хэмжээ гэж тус тус үнэлсэн байна.

¹ МУТХҮБ 2030 УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан

² ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан

³ Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн талаар санал, дүгнэлт боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

⁴ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн захиргааны төв, холбогдох төрийн захиргааны байгууллагаас үндсэн чиглэлийн төсөлд тусгуулахаар хүргүүлсэн саналыг хянаад төсөлд тусгасан, эсхүл тусгаагүй тухай үндэслэл, тайлбарыг энэхүү журмын 7 дугаар хавсралтын хүснэгт 2-т заасны дагуу боловсруулж, төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

ҮАГ-аас хэрэгжүүлсэн горим, арга зүйн дагуу хийсэн үнэлгээний дүнгээр нийт 127 зорилт, арга хэмжээнээс үр дүнтэй буюу бүрэн хэрэгжсэн 59, тодорхой үр дүнд хүрсэн 27, эрчимжүүлэх шаардлагатай 20, үр дүнгүй 21 арга хэмжээ буюу 2020 оны үндсэн чиглэлийн биелэлт дунджаар 73.2 хувьтай байна. /хэвсрэлт 1/

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилт, арга хэмжээний жилийн эцсийн биелэлт, бодлогын төрлөөр

Хүснэгт 2.

Бодлогын нэр	ТЕЗ	Сангийн яам	ЗГХЭГ	Аудитын дүн
Макро эдийн засгийн бодлого	74.1	76.4	58.2	56.7
Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	80.9	63.6	58.6	53.7
Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	87.2	83.2	76.4	74.0
Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого	87.6	83.5	82.6	74.0
Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	94.2	94.1	89.6	91.9
Нийт дундаж үнэлгээ	84.8	80.9	75.9	73.2

Эх сурвалж: ҮАГ

Дээрх хүснэгтээс харахад Макро эдийн засгийн бодлого, Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтийн нэгтгэл

Хүснэгт 3

Бодлогын нэр	Үр дүнтэй буюу бүрэн хэрэгжсэн	Тодорхой үр дүнд хүрсэн (70-99)	Эрчимжүүлэх шаардлагатай (31-69)	Үр дүнгүй (0-30)	Нийт
Макро эдийн засгийн бодлого	1	4	4	2	11
Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	4	6	8	10	28
Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	10	4	5	3	22
Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого	22	7	3	5	37
Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	22	6	-	1	29
Нийт	59	27	20	21	127


Эх сурвалж: ҮАГ

Үндсэн чиглэлд тусгагдсан зарим зорилт, арга хэмжээг урт болон дунд хугацааны бодлогын зорилтуудтай бүрэн уялдуулаагүй, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг бодитой тооцоо судалгаанд үндэслээгүй, хэрэгжилтийн явцад хариуцан хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хяналт хангалтгүйгээс арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.


ҮАГ-аас Үндсэн чиглэлийн биелэлтийг 2017-2020 онд үнэлсэн нэгтгэл

Дүрслэл 1.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн үнэлгээ, ерөнхий хэрэгжилт сүүлийн 4 жилд 68.4-73.2 хувийн хэрэгжилттэй байхад Засгийн газраас зорилт, арга хэмжээг эрчимжүүлэх, хэрэгжилтийг өсгөхөд анхаарч ажиллаагүй байна.



Эх сурвалж: ҮАГ



Эх сурвалж: ҮАГ

Салбараар нь авч үзвэл эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын үйл ажиллагаа сүүлийн 4 жилд томоохон өсөлт гараагүй нөхцөл байдал аудитын судалгаагаар гарсан байна.

БҮЛЭГ 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Макро эдийн засгийн болон Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлогын хүрээнд нийт 7 зорилт 39 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас үр дүнтэй бүрэн хэрэгжсэн 5, тодорхой үр дүнд хүрсэн 11, эрчимжүүлэх шаардлагатай 12, үр дүнгүй 11 арга хэмжээ байгаа нь хангалтгүй гэж үнэлэгдсэн ба энэ нь нийт арга хэмжээний 59 хувийг эзэлж байна.

1.1. Үндсэн чиглэлийн төсөлд 17,593.9 тэрбум төгрөг, 7,195.2 сая ам.доллар⁵ /Монголбанкны 2019.03.01-ны өдрийн хаалтын ханш 2635.34 төгрөгөөр тооцоход 18,969.7 тэрбум төгрөг/ нийт 36,563.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 355 шалгуур үзүүлэлттэй 268 зорилт арга хэмжээний саналыг 12 ТЕЗ, холбогдох 8 агентлаг, газраас боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Үндсэн чиглэлийн төсөлд төсөв захирагчдаас хүргүүлсэн санал, тусгагдаагүй арга хэмжээний нэгтгэл

Хүснэгт 4.

№	Бодлогын	ТЕЗ, агентлаг, газар		Үндсэн чиглэлийн төсөлд хүргүүлсэн санал				Хүргүүлсэн саналаас хасагдсан		
		нэр	тоо	арга хэмжээ	шалгуур үзүүлэлт	санхүүжих дүн		арга хэмжээ	шалгуур үзүүлэлт	санхүүжих дүн тэрбум. төгрөг
1	Макро эдийн засгийн бодлого	СЗХ, Монголбанк, Сангийн яам	3	32	33	0.7	-	23	24	0.7
2	Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	ХХААХҮЯ, ЭХЯ, УУХҮЯ, ЗТХЯ	4	49	82	3,782.5	6,887.3	21	14	603.3
3	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	БОАЖЯ, ОБЕГ, ҮХГ, БХБЯ	4	38	60	788.2	307.9	17	26	552.9
4	Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого	БСШУСЯ,ЭМЯ, ХХМТГ, ХНХЯ	4	59	89	2,636.3	-	23	38	1742.8
5	Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	ҮСХ, БХЯ, ХЗДХЯ, ГХЯ, МХЕГ, СХЗГ	6	90	91	10,386.0	-	66	66	10,294.1
Бодлогын нийт дүн			21	268	355	17,593.9	7,195.2	150	167	13,193.8

Эх сурвалж: ТЕЗ,агентлаг,газруудын санал

1.2. Үндсэн чиглэлийн төсөлд төсөв захирагчдаас хүргүүлж байгаа зарим зорилт, арга хэмжээний санал урт, дунд хугацааны бодлогын баримт бичигтэй бүрэн нийцээгүй, шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцоо судалгаагүйгээр хэт өндөр дүнгээр хүргүүлсэн байна.

1.3. Сангийн яам нь төсөв захирагчдаас ирүүлсэн зорилт, арга хэмжээг нэгтгэх, жил бүр тогтмол хэрэгждэг арга хэмжээ нэрээр нэмж тусгаж байгаа ч үндсэн чиглэлийн төсөлд саналыг тусгасан, тусгаагүй тухай үндэслэл, тайлбарыг тухайн төсөв захирагч нарт хүргүүлээгүй байна.

1.4. Сангийн яам холбогдох ТЕЗ, агентлаг, газруудаас ирүүлсэн саналыг нэгтгэн нийт 13,193.8 тэрбум төгрөг, 3,560.0 сая ам.долларын санхүүжих дүнтэй 167 шалгуур үзүүлэлт бүхий 150 зорилт, арга хэмжээг хасч, ХХААХҮЯ, СЗХ, БХБЯ, ЭМЯ, ГХЯ, БСШУСЯ, ЭХЯ, МХЕГ-ын саналд тусгагдаагүй 616.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 14 зорилт, арга хэмжээг нэмж, нийт 10,216.3 тэрбум төгрөгийн санхүүжилттэй 118 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төслийг Засгийн газарт өргөн барьсан байна. /хавсралт 3/

1.5. УИХ-ын Байнгын хороо⁶, нэгдсэн чуулганы хуралдаанаар Үндсэн чиглэлийн төслийг хэлэлцүүлэх явцад БСШУСЯ, БХБЯ, БОАЖЯ, ЭМЯ, Улсын ерөнхий прокурор, Сонгуулийн ерөнхий хорооны хариуцан хэрэгжүүлэх нийт 130.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 9 арга

⁵ Монголбанкны 2019.03.01-ны өдрийн ам.долларын хаалтын ханш 2635.34 төгрөг

⁶Эдийн засгийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо

хэмжээ нэмэгдэж, нийт 11,022.1 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 127 бодлогын зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан⁷ байна. Тухайлбал:

(11.7).Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын сургуулийн багшийг зөөврийн компьютертой болгох /улсын төсөв, гадаад эх үүсвэр 23.2 тэрбум төгрөг/ (БСШУСЯ)

(13.4).Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэн, төвүүдийн техник, тоног төхөөрөмж, компьютерыг шинэчлэн нийлүүлэх /улсын төсөв 0.6 тэрбум төгрөг/ (БСШУСЯ)

(12.6).Соёлын баримтат өвийг хамгаалах, музей, түүх, соёлын өвийн сэргээн засварлалтын ажлыг эрчимжүүлэх; (БСШУСЯ)

(12.7). ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн бүртгэлд бүртгэгдсэн Монгол Улсын соёлын өвийг хамгаалах, Бурхан Халдун уулын соёлын өвийн менежментийн захиргааг байгуулах; (БСШУСЯ)

(13.3).Ботаникийн цэцэрлэгийг тохижуулах, байгалийн ургамлын үндэсний генобанканд шаардлагатай барилгыг барих /улсын төсөв 8.0 тэрбум төгрөг/ (БОАЖЯ)

(8.15).Нийслэл, аймгийн төвийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил /улсын төсөв 85.0 тэрбум төгрөг/ (БХБЯ)

(15.5).Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх /улсын төсөв 2.0 тэрбум төгрөг/ (ЭМЯ)

(17.18).Прокуратурын байгууллагын боловсон хүчний чадавхыг сайжруулах, барилга, конторын их засвар, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх /улсын төсөв 12.0 тэрбум төгрөг/ (УЕП)

(17.19).Сонгуулийн санал тооллогын техник хэрэгслийг шинэчлэх арга хэмжээг авах (СЭХ)

Макро эдийн засгийн бодлогын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлэх, эдийн засгийн тогтвортой орчныг хангахад чиглэсэн зорилтын хэрэгжилт бүрэн хангагдаагүй, биелэлт 56.7 хувь байна.

1.6.Макро эдийн засгийн бодлогын 2 зорилт 11 арга хэмжээг Сангийн яам, Монголбанк, СЗХ, ХНХЯ хариуцан хэрэгжүүлсэн бөгөөд үр дүнтэй бүрэн хэрэгжсэн 1, тодорхой үр дүнд хүрсэн 4, эрчимжүүлэх шаардлагатай 4, үр дүнгүй 2 арга хэмжээ тус тус байна.

1.7. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “МУТХҮБ-2030”-ын Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим, 2.1.6-т “Макро эдийн засгийн бодлого”, Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим, 2.2.1-д “Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал”-ын хүрээнд 4 зорилт арга хэмжээг I үе шат (2016-2020)-нд хэрэгжүүлэхээр дараах байдлаар тус тус төлөвлөж баталсан байна. Тухайлбал:

Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим:

Төлбөрийн тэнцлийг алдагдалгүй төлөвлөн хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангаж, инфляцыг тогтвортой нам түвшинд барих.

“Макро эдийн засгийн бодлого”-I үе шат (2016-2020) :

- Зорилт 1-ийн хүрээнд “Улсын төсвийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас ихгүй байхаар төлөвлөх”.
- Зорилт 2-ын хүрээнд “Санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгож, санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 10 хувьд хүргэн нэмэгдүүлэх, арилжааны банкны эзлэх хувийг 90 хувьд хүргэн бууруулах, даатгалын зах зээлийн эзлэх хувийг өсгөх”.
- Зорилт 3-ын хүрээнд “Хөгжлийн санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгоно. Тулгамдаж байгаа гадаад өрийн асуудлыг эдийн засаг, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр бүтцийг өөрчлөн зохицуулж, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 58,6 хувиас хэтрүүлэхгүй байж, өрийн зохистой түвшинг хангах”.

“Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал” -I үе шат (2016-2020) :

- Зорилт 2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна” гэснийг хэрэгжүүлэх I үе шат (2016-2020): “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 66 хувьд, ажилгүйдлийн түвшинг 6 хувьд хүргэх...”

⁷ УИХ-ын 2019 оны 54 дугаар тогтоолоор

1.8. УИХ-аар 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай” хуулийг анх баталж, уг хуульд 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна. /хавсралт 4/

1.9. “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай” хуулиар ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ 6 хувиас (-1) хувь, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэлд ДНБ-ий эзлэх хувь (-5.1) хувиас (-12.5) хувь болж өөрчлөгдөж батлагдсан нь “МУТХҮБ-2030”-ын *Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим*, Макро эдийн засгийн бодлогын зорилт 1-тэй нийцээгүй байна. Үүнд:

Хүснэгт 5.

№	МУТХҮБ-2030			Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар баталсан		
	Зорилт, арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрэх түвшин үр дүн	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2020.08.28-ны өдөр	2019.05.30-ны өдөр
					Төсвийн хүрээний мэдэгдэл 2020 он	2020 он
2	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	2016-2030 онд	6.6 хувиас доошгүй байна.	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	-1	6
2.1.6	Зорилт 1-т “Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулах”	I үе шат (2016-2020)	Улсын төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувиас ихгүй байхаар төлөвлөх	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-4,846.6	-2,074.7
				Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-12.5	-5.1

Эх сурвалж: УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “МУТХҮБ-2030”, Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль.

Дүрслэл 3.

1.10. Макро эдийн засгийн бодлогод “МУТХҮБ-2030”-аас 10, ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс 4, “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-өөс 1, Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогоос 1, нийт 16 зорилт, арга хэмжээ бодлогын баримт бичиг, хөтөлбөр тусгагдсан байна.



Эх сурвалж: Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

1.11. Үндсэн чиглэлд тусгагдсан “Макро эдийн засгийн бодлого”-ын 1.3, 2.4, 2.5 дахь зорилт, арга хэмжээний тайлант оны хүрэх түвшин, үр дүн нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн холбогдох заалтад агуулгын хувьд нийцээгүй, 2020 оны хүрэх түвшнээс зөрүүтэй, тухайн жилийн шалгуур, хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт хоорондоо нийцээгүй байна. Үүнд:

МУТХҮБ-2030:

- Үндсэн чиглэл 1.3. “Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх” гэсэн арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн 2020 оны хүрэх түвшин, үр дүнг “Ажилгүйдлийн түвшин 6,5 хувиас ихгүй” гэж баталсан нь “МУТХҮБ 2030”-ын 2.2.1-ийн Зорилт-2-ын I үе шат (2016-2020)-нд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 66 хувьд, ажилгүйдлийн түвшинг 6 хувьд хүргэх...”, Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын 5.2. Ажилгүйдлийн түвшин 2020 онд 5.6% байна” гэж зааснаас 0.5-0.9 пунктээр зөрүүтэй баталсан нь нийцээгүй. /ХНХЯ/

ЗГҮАХ 2016-2020:

- Үндсэн чиглэл 2.4 “Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлж, валютын зохицуулалт, векселийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох”, 2.5 “Санхүүгийн салбар дахь зээлийн хүү, чанаргүй активыг бууруулахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, санхүүгийн

хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх “ тусгасан арга хэмжээ нь ЗГҮАХ-ийн 1.2.1 “Төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах”, 1.2.2.”Төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулж, инфляцын тогтвортой байдлыг хангах”, 1.2.3.”Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх замаар ойрын хугацаанд төлөх гадаад өр төлбөрийг санхүүжүүлэх “ гэсэн арга хэмжээтэй нийцээгүй. /Монголбанк, Сангийн яам,СЗХ/

Үндсэн чиглэл-2020:

- Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогын “Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, жижиг, дунд үйлдвэрийг бодлогоор дэмжинэ” зорилт-2-ын 4.6. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг “Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар” гэж тусгасан байхад 2020 онд хүрэх түвшин,үр дүнг “21 аймагт үйлдвэр байгуулах “ гэж тоогоор тусгасан нь хоорондоо нийцээгүй байна.

Макро эдийн засгийн бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилт нь “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр зорилтот үр дүнд хүрээгүй байна.

1.12. Үндсэн чиглэлийн биелэлтийг оны эхнээс жигд ханган зохион байгуулан хэрэгжүүлэхийг Засгийн газар, Монголбанк, СЗХ болон холбогдох бусад хариуцан хэрэгжүүлэгч байгууллагад УИХ⁸-аас үүрэг болгожээ.

1.13. Макро эдийн засгийн бодлогын 2 зорилтод хамаарах 11 арга хэмжээнээс эрчимжүүлэх шаардлагатай 4-6 арга хэмжээ байна. Тухайлбал:

Хүснэгт 6.

Бодлогын зорилтын нэр	Эрчимжүүлэх шаардлагатай (31-69)	Үр дүнгүй (0-30)
Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлнэ.	2	1
Макро эдийн засгийн тогтвортой орчныг хангахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлого хэрэгжүүлнэ.	2	1

Эх сурвалж: УАГ

Дүрслэл 4.

1.14. “Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй болон аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг хангах” арга хэмжээний хүрээнд “ДНБ-ий бодит өсөлт 6 хувь” байхыг “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хууль”-д ДНБ-ий бодит өсөлт (-1) хувь гэж өөрчилсөн боловч 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ⁹-ий бодит өсөлт (-5.3) хувийн¹⁰ бууралттай гарсан нь дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр зорилтот үр дүнг хангаагүй байна.



Эх сурвалж: УСХороо 1212.mn

- 2020 онд ДНБ оны үнээр 36,958.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 322.3 тэрбум төгрөг буюу (0.2) хувиар буурсан байна. ДНБ-ий бууралтад уул уурхай, олборлолтын салбар (-2) хувь, уул уурхайн бус салбар (-3.4) хувиар буурсан нь тус тус голлон нөлөөлжээ.

⁸ УИХ-ын 2019 оны 54 дугаар тогтоолын 2 дахь заалт


⁹ Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм.

¹⁰ -Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнэ /18,137.5 тэрбум төгрөг/-ээр тооцоход -5.3 хувиар буурсан. УСХ-оос гаргасан Дотоодын нийт бүтээгдэхүүн-2020 оны урьдчилсан гүйцэтгэлийн танилцуулга 2021 оны 02 дугаар сарын 18. / хуудас 4/

- Дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлын улмаас БНХАУ, ОХУ-ын хилийн боомтуудад хязгаарлалт хийгдсэн. Үүнээс шалтгаалж экспортын орлого өмнөх оноос 0.6 хувиар, гадаад эрэлт 6.4 хувиар буурсан нь эдийн засгийн салбаруудад сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Дүрслэл 5.

1.15. МУТХҮБ-2030-ын Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчимд “Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 6.6 хувиас доошгүй байна” гэсэн нөхцөл дунд хугацаанд бүрэн хангагдаагүй байна.



Эх сурвалж: УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “МУТХҮБ-2030”, УСХ-ны 1212.mn сайтын мэдээлэл

Хүснэгт 7.

1.16. Эдийн засагт голлох уул уурхайн болон уул уурхайн бус салбаруудын оролцоо дараах хувиар нөлөөлж байна. Үүнд:

ДНБ-ий өсөлт, бууралтад уул уурхай, уул уурхайн бус салбарын оролцоо

Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он
ДНБ-ий өсөлт,бууралт	7.2	5.2	-5.3
Уул уурхайн салбар	1.3	-0.1	-2
Уул уурхайн бус салбар	5.9	5.2	-3.4

Эх сурвалж: УСХ-оос гаргасан Дотоодын нийт бүтээгдэхүүн-2020 оны урьдчилсан гүйцэтгэлийн танилцуулга 2021 оны 02 дугаар сарын 18. /хуудас 5/

Дүрслэл 6.


1.17. Ажилгүйдлийн түвшинг 6.5 хувиас ихгүй байхаар тусгасан ч 2020 оны жилийн эцсийн дүнгээр ажилгүйдлийн түвшин 7.6 хувьтай байгаа нь зорилтот түвшнээс 1.1 пунктээр илүү, өмнөх оноос 2.4 пунктээр бага байна.



Эх сурвалж: ЯАГ, УСХОроо 1212.mn

Дүрслэл 7.


1.18. Инфляцын түвшин 2020 оны эцэст 2.3 хувьтай байгаа нь зорилтот түвшнээс 5.7 пунктээр бага байна. Үүнд цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил суларч, эрэлтийн шалтгаантай инфляц саарсантай холбоотой байна.



Эх сурвалж: УАГ, ҮСХороо 1212.mn

Дүрслэл 8.

1.19. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр -4,539.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл”-д тусгасан¹¹ Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлээс 307.4 тэрбум төгрөгөөр бага, нэгдсэн төсвийн алдагдлын дээд хэмжээ, ДНБ-ий(-12.3) хувийг эзэлж байгаа нь зорилтот шалгуурыг хангаж байна



Эх сурвалж: ҮСХороо “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn

“Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны үзүүлэлт” /тэрбум төгрөг, хувь/

Хүснэгт 8.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2020 оны төсөв /батлагдсан/	2020 урьдчилсан /гүйцэтгэл/	зөрүү
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ	9,730.9	9421.6	309.3
Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ	14,577.5	13960.8	616.7
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-4,846.6	-4539.2	-307.4
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-12.5	-12.3	0.2

Эх сурвалж: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хууль (2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр баталсан), ҮСХ “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан” 1212.mn.

Дүрслэл 9.

1.20. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 62.3 хувьтай гарч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4¹²-т “...2020 оны төсвийн жилд 70 хувиас...” гэж заасан шаардлагатай нийцсэн байна.



Эх сурвалж: ҮСХороо 1212.mn

¹¹ УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр баталсан Монгол Улсын 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсөөллийн тухай хууль

¹² 2016 оны 09 сарын 09-ны өдрийн ТТБТухай хуулийн өөрчлөлтөөр “Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 70 хувиас хэтрэхгүй байх”

Хүснэгт 9.

1.21. Харин 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан ДНБ-ий (ӨҮЦ) эзлэх хувиас 0.1 нэгж хувиар, “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т заасан Засгийн газрын өрийн ДНБ-ий (ӨҮЦ) эзлэх хувиас¹³ 0.8 нэгж

Засгийн газрын 2019-2020 оны гадаад өр, гадаад валют, ДНБ-ий өсөлтийн харьцуулалт /тэрбум төгрөг, хувь/				
Үзүүлэлт	Хамрагдах хугацаа			тайлбар
	2019.12.31	2020.12.31	хувь	
Төгрөгийн ам.доллартой харьцах ханш	2734.33	2848.89	(4.02)	суларсан
ДНБ-ий өсөлт, бууралт	5.2	-5.3	-10.5	буурсан
Засгийн газрын гадаад өр	20,443.5	24,848.1	121.5	өссөн


Эх сурвалж: Монголбанкнаас зарласан ханшийн статистик, УСХ-ны 1212.тп цахим сайт

хувиар илүү байгаа нь Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 2019 оноос 21.5 хувиар өссөн, ДНБ-ий өсөлт өмнөх оноос -10.5 хувиар буурсантай холбоотой байна. Энэ нь валютын ханш өсөх үед өрийн стратегийн дунд хугацааны баримт бичиг биелэгдэхгүй байх эрсдэлтэй байна.

1.21. Харин 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан ДНБ-ий (ӨҮЦ) эзлэх хувиас 0.1 нэгж хувиар, “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т заасан Засгийн газрын өрийн ДНБ-ий (ӨҮЦ) эзлэх хувиас¹⁴ 0.8 нэгж хувиар илүү байгаа нь Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 2019 оноос 21.5 хувиар өссөн, ДНБ-ий өсөлт өмнөх оноос -10.5 хувиар буурсантай холбоотой байна. Энэ нь валютын ханш өсөх үед өрийн стратегийн дунд хугацааны баримт бичиг биелэгдэхгүй байх эрсдэлтэй байна.

Дүрслэл 10.

1.22. МУТХҮБ-2030-ын Макро эдийн засгийн бодлогын¹⁵ “Хөгжлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, гадаад, дотоод өрийн удирдлагын зохистой тогтолцоог бий болгон төлөвшүүлнэ” зорилт-3-ын I үе шат (2016-2020)-нд “...гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 58.6 хувиас хэтрүүлэхгүй байж, өрийн зохистой түвшинг хангах...” гэж заасан ч 2017 он, 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр хангагдаагүй байна.



Эх сурвалж: УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “МУТХҮБ-2030”, УСХ-ны 1212.тп сайтын мэдээлэл

1.23. Урт болон дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэх явцад давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр тооцоолоогүй эрсдэл бий болох үед нарийвчилсан зохицуулалт хийх бодлогын¹⁶ арга хэмжээ авч байгаа ч тухайн жилийн зорилтот түвшин хангагдахгүй байна.

¹³ УИХ-ын 2019 оны 55 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-ийн Засгийн газрын өрийн тусгай шаардлагын төсөөлөлд -өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь-54.3%, -Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь-65.8%... гэж тусгасан.

¹⁴ УИХ-ын 2019 оны 55 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-ийн Засгийн газрын өрийн тусгай шаардлагын төсөөлөлд -өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь-54.3%, -Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь-65.8%... гэж тусгасан.

¹⁵ УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.6-т “Макро эдийн засгийн бодлого”

¹⁶ УИХ-ын 2020.04.09-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор “Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээ”, УИХ-ын 2020.04.29-ны өдрийн 32 дугаар тогтоолоор “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээ”

Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлогын зарим арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүйн улмаас зорилтот үр дүнг хангахуйцаар хэрэгжүүлээгүй, биелэлт 53.7 хувь байна.

1.24. Эдийн засгийн өсөлтийг дэмжих 5 зорилт 28 арга хэмжээг ХХААХҮЯ, УУХҮЯ, ЭХЯ, ЗТХЯ хариуцан хэрэгжүүлсэн бөгөөд үр дүнтэй бүрэн хэрэгжсэн 4, тодорхой үр дүнд хүрсэн 6, эрчимжүүлэх шаардлагатай 8, үр дүнгүй 10 арга хэмжээ тус тус байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлогын хэрэгжилт

Хүснэгт 10.

Зорилт, арга хэмжээ	Эрчимжүүлэх шаардлагатай (31-69)	Үр дүнгүй (0-30)
УУХҮЯ	2	1
ХХААХҮЯ	4	2
ЭХЯ	2	4
ЗТХЯ	-	3

Эх сурвалж: УАГ

Дүрслэл 11.

1.25. Эдийн засгийн бодлогод “МУТХҮБ-2030”-аас 22, ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс 24, Төрөөс баримтлах салбарын бодлогоос 17, нийт 63 зорилт, арга хэмжээ бодлогын баримт бичиг, хөтөлбөр тусгагдсан байна.



Эх сурвалж: Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

1.26. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “МУТХҮБ-2030”-ын 2.1-т “Эдийн засгийн тогтвортой хөгжил”-ийн зорилтыг хангахаар “Хөдөө аж ахуйн салбар”, “Аж үйлдвэрийн салбар”, “Эрдэс баялгийн салбар”, “Дэд бүтцийн салбар”-ын I үе шат (2016-2020)-нд 14 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

1.27. Үндсэн чиглэлийн төсөлд ХХААХҮЯ, УУХҮЯ, ЭХЯ, ЗТХЯ-аас “Эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого”-ын хүрээнд нийт 82 шалгуур үзүүлэлт бүхий 3,782.5 тэрбум төгрөг, 6,887.3 сая ам.доллар /Монголбанкны 2019.03.01-ны өдрийн хаалтын ханш 2635.34 төгрөгөөр тооцоход 18,150.4 тэрбум төгрөг/ нийт 21,932.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 49 зорилт, арга хэмжээний саналыг боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн байна. Хүргүүлсэн саналд 6,887.3 сая ам.доллар байгаа нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д¹⁷ заасантай нийцээгүй байна.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд ХХААХҮЯ, УУХҮЯ, ЭХЯ, ЗТХЯ-с хүргүүлсэн санал, тусгагдаагүй арга хэмжээний нэгтгэл

Хүснэгт 11.

№	Яам, агентлаг	хүргүүлсэн санал				хасагдсан		
		арга хэмжээ	шалгуур үзүүлэлт	санхүүжих дүн		арга хэмжээ	шалгуур үзүүлэлт	санхүүжих дүн /тэрбум төгрөг/
				тэрбум төгрөг	сая ам. доллар			
1	ХХААХҮЯ	18	21	1,250.4		8	1	603.3
2	УУХҮЯ	15	23	2,261.2	3253.0	11	9	0

¹⁷ 4.1. Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.

3	ЭХЯ	10	33	123.9	467.9	0	4	0
4	ЗТХЯ	6	5	147	3,166.4	2	0	0
Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого		49	82	3,782.5	6,887.3	21	14	603.3

Эх сурвалж: ТЕЗ-ийн санал

1.28. Үндсэн чиглэлийн төсөлд тусгуулахаар хүргүүлсэн нийт 22,744.3 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр нь тухайн ТЕЗ-ийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан 2020 оны төсвийн зарлагын дээд хэмжээ 1,747.1 тэрбум төгрөгөөс 20,185.9 тэрбум төгрөг буюу 7.9 дахин их байгаа нь тухайн үед мөрдөгдөж байсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5¹⁸-т заасан хязгаараас давсан байна. Тухайлбал:

ТЕЗ-ийн багцын 2020 оны төсвийн төсөлд тусгасан зарлагын дээд хязгаар, Үндсэн чиглэлийн төсөлд тусгуулах саналын дүнгийн харьцуулалт

Хүснэгт 12.

ТЕЗ-ын нэр	2020 оны төсвийн төсөлд тусгасан зарлагын дээд хязгаар /тэрбум.төгрөг/	Үндсэн чиглэлд		Сая ам.долларыг тэрбум төгрөгт шилжүүлсэн /1\$ x 2635.34 төгрөг/	Нийт хүргүүлсэн санал /тэрбум төгрөг/	тухайн салбарын зарлагын дээд хязгаараас
		хүргүүлсэн санал				
		Тэрбум төгрөг	Сая ам.доллар			
УУХҮЯ	124.7	2,261.2	3,253.0	8,572.8	10,834.0	-10,709.3
ХХААХҮЯ	1,228.2	1,250.4		0.0	1,250.4	-22.2
ЭХЯ	65.4	123.9	467.9	1,233.1	1,357.1	-1,291.7
ЗТХЯ	328.8	147	3,166.4	8,344.5	8,491.5	-8,162.7

Эх сурвалж: УУХҮЯ, ХХААХҮЯ, ЭХЯ, ЗТХЯ-ны шилэн данс

1.29. “Эдийн засгийн бодлого”-ын зарим арга хэмжээний тайлант онд шаардагдах хөрөнгийн хэмжээ нь ЗГҮАХ-т тусгасан холбогдох заалтын 2020 оны төсвийн дүнгээс зөрүүтэй тусгасан байна. Тухайлбал:

ЗГҮАХ 2016-2020:

- ЗГҮАХ-ийн 2.32.5-т 2020 онд улсын төсөв 18.8 тэрбум, 2.32.4-т 2020 онд улсын төсөв 5.2 тэрбум, нийт 23.9 тэрбум төгрөгөөр тусгасан, Үндсэн чиглэл 3.2. “Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх” арга хэмжээний 2020 онд шаардагдах хөрөнгө улсын төсөв 25.0 тэрбум төгрөгөөр баталсан нь дунд хугацааны төсвөөс 1.1 тэрбум төгрөгөөр илүү; /ХХААХҮЯ/
- ЗГҮАХ-ийн 2.36.2-т 2020 онд Улсын төсөв, Орон нутгийн төсөв, гадаад эх үүсвэрээр 1.0 тэрбум, 2.36.5-т Улсын төсөв, Орон нутгийн төсвөөр 3.0 тэрбум, нийт 4.5 тэрбум төгрөгөөр тусгасан, Үндсэн чиглэл 3.4. “Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүй, хариуцлагын тогтолцоо, бэлчээрийн менежментийг сайжруулах” арга хэмжээний 2020 онд улсын төсөв 1.7 тэрбум, “Тэмцсэн бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж байгаа үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх арга хэмжээ” улсын төсөв 5.0 тэрбум, нийт 6.7 тэрбум төгрөг баталсан нь дунд хугацааны төсвөөс 2.2 тэрбум төгрөгөөр илүү; /ХХААХҮЯ/
- ЗГҮАХ-ийн 2.50.1-т 2020 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, бусад эх үүсвэрээр 12.5 тэрбум, 2.50.2-т улсын төсөв 20.0 тэрбум, нийт 32.5 тэрбум төгрөг тусгасан, Үндсэн чиглэл 4.4. “Жижиг, дунд үйлдвэр болон загвар хоршоодыг санхүү, зээлийн бодлогоор дэмжих”-ын 2020 онд өөрийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр 50.0 тэрбум төгрөг гэж баталсан нь дунд хугацааны төсвийн дүнгээс 17.5 тэрбум төгрөгөөр илүү; /ХХААХҮЯ/
- ЗГҮАХ-ийн 2.48.7-т 2020 онд улсын төсөв, гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 100.0 тэрбум, 2.57.1-т улсын төсөв, гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 93.0 тэрбум, нийт 193.0 тэрбум төгрөг тусгасан, Үндсэн чиглэл 4.6. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахаар 2020 онд Хөгжлийн банкаар 500.0 тэрбум төгрөг гэж баталсан нь 307.0 тэрбум төгрөг буюу 2.6 дахин өсгөж баталсан нь тус тус нийцээгүй; /ХХААХҮЯ/

¹⁸ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтын нийт дүн нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан тухайн салбарын зарлагын дээд хязгаараас хэтрэхгүй байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлогын зарим арга хэмжээг хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулах, удирдлага зохион байгуулалт, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

1.30. Эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогын 5 зорилтын эрчимжүүлэх шаардлагатай 8, үр дүнгүй 10 арга хэмжээ байна. Тухайлбал:


Хүснэгт 13.

Бодлогын зорилтын нэр	Эрчимжүүлэх шаардлагатай (31-69)	Үр дүнгүй (0-30)
Бүтээн байгуулалт, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн суурь дэд бүтэц, зам тээврийн салбарыг хөгжүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ	-	3
Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, жижиг, дунд үйлдвэрийг бодлогоор дэмжинэ	3	2
Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ	2	1
Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ	2	4
Мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимтэй хөгжүүлж, бэлчээрийн менежментийг сайжруулна	1	-

Эх сурвалж: УАГ

Дүрслэл 12.


1.31. Аж үйлдвэрийн салбарт 2020 онд нийт 1,787.8 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл бий болсноос Уул уурхайн олборлох үйлдвэрлэл 1,318.0 тэрбум, Боловсруулах аж үйлдвэр 328.0 тэрбум, Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж 141.8 тэрбум төгрөгийн үйлдвэрлэлийг бий болгосон нь 2019 онтой харьцуулахад 46.2 хувийн өсөлттэй гарсан байна



Эх сурвалж: УЦХ 1212.тн

Дүрслэл 13.

1.32. Монгол Улсад 2020 онд нийт 67.1 сая толгой мал бүртгэгдсэн нь өмнөх оноос 5,6 хувиар буурсан, 2020 онд малын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх хээлтүүлэгч болон цөм сүргийн малын тоо 1.5 сая толгойд хүргэх зорилтоос 0.5 сая толгой малыг мэдээллийн нэгдсэн санд оруулсан нь 35.1 хувийн биелэлттэй байна.



Эх сурвалж: УЦХ 1212.тн

1.33. “МУТХҮБ-2030”-ын Хөдөө аж ахуйн салбарт “Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх”, Монгол мал үндэсний хөтөлбөрт¹⁹ 2021 оны эхэнд малын тоо 36.5 сая.толгой байхаар заасан ч 2020 оны жилийн эцэст 67.1 сая толгой буюу зорилтот түвшнээс 30.6 сая.толгой малаар хэтэрсэн буюу 1.8 дахин өссөн, үүнээс малын төрлөөр доорх байдлаар зохистой харьцаа хангагдаагүй нь мал нядалгааны цехийг 313 хүргэхээс 103 байгаа, малыг эдийн засгийн эргэлтэд хангалтгүй оруулж байгаатай холбоотой байна. Үүнд:

Монгол мал үндэсний хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлт, 2020 оны гүйцэтгэлийн харьцуулалтын нэгтгэл


Хүснэгт 14.

Үзүүлэлт	Монгол мал үндэсний хөтөлбөрт заасан 2021 оны эхэнд	2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл	зохистой харьцааны зөрүү
Малын тоо /сая.толгой/	36.5	67.1	-30.6
- Тэмээ, хувь	0.9	0.7	0.2
- Адуу, хувь	8.2	6.1	2.1
- Үхэр, хувь	13.8	7	6.8
- Хонь, хувь	45.4	44.7	0.7
- Ямаа, хувь	32	41.3	-9.3

Эх сурвалж: Монгол мал үндэсний хөтөлбөр, YCX-1212.mn

Дүрслэл 14.

1.34. Хөдөө аж ахуйн салбарын хүрээнд “...мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг хөрш орнуудын зах зээлд гаргах...” гэж зорилтот түвшинг баталснаас 2020 онд мал, амьтны гаралтай 53.2 сая ам. долларын бүтээгдэхүүнийг экспортод гаргасан. 2017-2019 онтой харьцуулахад 78.8 хувиас 54.4 хувиар буурсан нь Монгол мал үндэсний хөтөлбөрт “... Монгол малын эрүүл мэндийг баталгаажуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах” хүрээнд Монгол Улс нь ДМАЭМБ-аас тогтоосон /үхрийн цээж, үхрийн тархины эд сархиатах шүлхий, хонь



Эх сурвалж: YCX 1212.mn

ямааны цэцэг өвчнөөр тайван өвчингүй байх/ гэрчилгээ аваагүй байгаа нь мал, малын гаралтай бүтээгдэхүүний экспортын бууралтад тодорхой нөлөө үзүүлжээ.

Дүрслэл 15.

1.35. 2020 онд “Хүн амын эрүүл, аюулгүй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хангалтыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд “Жимс, жимсгэнэ” тариалах шинээр нэмэгдэх талбайн хэмжээ, 8.0 мян.га-д хүргэхээс 0.06 га-д хүрч 0.1%-ийг эзэлж байгаа, 2016-2020 онд Улсын хэмжээнд жимс, жимсгэнийн тариалалт 2.7 мян.га-с 3.0 мян.га байгаа нь зорилтот үр дүнг хангаагүй байна.




Эх сурвалж: YCX-1212.mn

¹⁹ УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн Тав.Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтээр малын тоо 2008 оны суурь түвшин-43.3 сая толгой, /2012 онд 33.3 сая толгой, 2015 онд 35.3 сая толгой, 2021 оны эхэнд 36.5 сая толгойд хүрэх/

Дүрслэл 16.

1.36. Улсын нийт экспорт 2020 онд Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах зорилтын хүрээнд экспортын боловсруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт, 2.0-оос доошгүй хувиар өсгөхөөс 0.6 хувиар өссөн нь үр дүн хангалтгүй байна.



Эх сурвалж: YCX-1212.mn

1.37. “МУТХҮБ-2030”-ын Аж үйлдвэрийн салбарын зорилт 1-ын I үе шат (2016-2020)-нд “...Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэх” гэж заасан бөгөөд боловсруулах үйлдвэр 2016-2017 онд 27.4 хувиас 18.2 хувь, 2020 онд 29.8 хувьд хүрч зорилтот түвшинг хангасан байна.

Дүрслэл 17.



Эх сурвалж: YCX-1212.mn

- (4.4). “Жижиг, дунд үйлдвэр болон загвар хоршоодыг санхүү, зээлийн бодлогоор дэмжих” ажлын байрны тооны өсөлт 20 хувиар өсөхөөс шинээр 1497 ажлын байр бий болсон ч 2019 онтой харьцуулахад 49.6 хувиар, хадгалагдсан ажлын байр өмнөх онтой харьцуулахад 34.3 хувиар тус тус буурсан нь үр дүнд хүрээгүй, (ХХААХҮЯ)
- (4.6). “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд 21 аймагт үйлдвэр байгуулахаас 7 аймагт /Баян-өлгий аймагт арьс шир боловсруулах, Булган аймагт сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, Говь-алтай аймагт дахин боловсруулах, Говь-сүмбэр аймагт мах, махан бүтээгдэхүүн, Завхан аймагт ноос угаах, мах боловсруулах, Өвөрхангай аймагт био бордоо үйлдвэрлэл, Увс аймагт чацарганын шүүс, ундаа тос цай чанамал боловсруулах үйлдвэр/ үйлдвэр байгуулсан нь зорилтот үр дүнг хангаагүй байна. (ХХААХҮЯ)
- (5.3). Эдийн засгийн өсөлтийг дэмжих хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх хүрээнд: (УУХҮЯ)
- (5.3.1). Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, 40 хувьд хүргэхээс үйлдвэрийн барилгын ажил эхлээгүй. (УУХҮЯ)
- (5.3.2). Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах шугам хоолойн төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлын явц 100 хувьд хүргэхээс ТЭЗҮ боловсруулагдаагүй, (УУХҮЯ)
- (5.3.3). Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, 15 хувьд хүрэхээс барилгын ажил эхлээгүй, (УУХҮЯ)

- (5.3.4). Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, 15 хувьд хүргэхээс үйлдвэр барих ажил эхлээгүй, (УУХҮЯ)
- (5.3.5). Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр болон Төмөртэйн ордын баяжуулах үйлдвэрийн барилгын ажлын явц 10 хувьд хүрэхээс үйлдвэр байгуулаагүй нь зорилтот түвшин, үр дүн хангагдаагүй 12 хувийн биелэлттэй байна. (УУХҮЯ)
- (5.4). Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоог сайжруулж, Евро-5 стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх, шатахууны хэмжээг 50 хувьд хүргэхээс шатахууны импорт, хэрэглээ 2020 онд 229.7 мянган тонн буюу нийт шатахууны 14.9 хувийг эзэлж байгаа нь зорилтот үр дүнд хүрээгүй, (УУХҮЯ)

Дээрх байдал нь МУТХҮБ-2030-ын Аж үйлдвэрийн салбар Зорилт 3-ын I үе шат (2016-2020)-нд “Гол нэр төрлийн ...дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нүүрс боловсруулах, ...үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх”. Зорилт 4-ийн хүрээнд “Жилд 100.0 мянган тонн ган бөмбөлөг, ...үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийн үйлдвэрийг ашиглалтад оруулах.” гэсэн зорилтот үр дүн хангагдаагүй байна.

Дүрслэл 18.

1.39. “МУТХҮБ-2030”-ын Дэд бүтцийн салбарын зорилт 1-ын I үе шат (2016-2020)-нд “Эрчим хүчний хэрэгцээнийхээ 85 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах” гэж заасан ч 2020 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр нийт эрчим хүчний хэрэглээ 8,590.5 сая.кВт.цаг, үүнээс 6,884.9 сая.кВт.цаг /80,1%/ эрчим хүчийг дотоодын эх үүсвэрээр, 1,705.6 сая.кВт.цаг /19,9%/ эрчим хүчийг импортоор авч зорилтын хэрэгжилт 4,9 хувиар доогуур байна.




Эх сурвалж: YCX-1212.mn

1.40. Үндсэн чиглэлд цахилгаан станцуудыг өргөтгөх болон шинэ цахилгаан станцуудын барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр /2143.5 МВт-р нэмэгдүүлэх/ 13 арга хэмжээ тусгаж өгсөн байна. Үүнээс 1 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 2 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, санхүүжилт шийдвэрлэгдээгүй, тендер шалгаруулалт хойшилсон, Ковид-19 цар тахал зэргээс шалтгаалан 3 арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрээгүй бол 7 арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- (6.2.1) Тавантолгойн 300 МВт-ын цахилгаан станцын барилгын ажлын явц, хувиар / Төсөл хэрэгжүүлэх загвар өөрчлөгдсөн тул барилга угсралтын ажил эхлээгүй./ (ЭХЯ)
- (6.2.2) Багануурын 700 МВт-ын дулааны цахилгаан станц барих төслийн барилгын ажлын явц, хувиар / 2020 онд концессын гэрээний нэмэлт өөрчлөлтөөс шалтгаалан төслийн талбайд барилгын ажил үргэлжлээгүй байна./ (ЭХЯ)
- (6.4.1) Эгийн голын 315 МВт-ын усан цахилгаан станц барих төслийн биологийн олон янз байдлын судалгааг хийх ажлын явц, хувиар /БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооноос төслийн талаар ОХУ-тай нэгдмэл ойлголтод хүрэх хүртэл концессын санхүүжилт хийхийг түр зогсоосон./ (ЭХЯ)
- (6.4.3) Баруун бүсэд сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх төслийн барилгын ажлын явц, хувиар /Нийтдээ 40.5МВт суурилуулсан чадалтай сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг баруун бүсэд барьж байгуулахаас биелэлт 10%/ (ЭХЯ)
- (6.5.5) 220 кВ-ын Дархан дэд станцыг өргөтгөх, шинэчлэх төслийн барилга угсралтын ажлын явц, хувиар /2020 оны улсын төсөвт зураг төсөл боловсруулахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх санал хүргүүлсэн боловч тусгагдаагүй/ (ЭХЯ)

Дүрслэл 19.

1.41. “МУТХҮБ-2030”-ын Дэд бүтцийн салбарын зорилт 2-ын I үе шат (2016-2020)-нд Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 20-д хүргэхээс 2020 онд үйлдвэрлэсэн нийт эрчим хүчний 10,1 хувийг эзэлж байгаа нь зорилтот түвшнээс 50% доогуур байна.



Эх сурвалж: YCX-1212.mn

Дүрслэл 20.

1.42. “МУТХҮБ-2030”-ын Дэд бүтцийн салбарын зорилт 3-ын I үе шат (2016-2020)-нд “...олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 1600 км-ээр нэмэгдүүлэх...” арга хэмжээний хүрээнд 2020 онд 301,1 км авто зам шинээр ашиглалтад оруулахаар төлөвлөснөөс 323,6км авто замыг шинээр ашиглалтад оруулж, дунд хугацаанд нийт 2,956.4 км авто замыг ашиглалтад оруулж зорилго бүрэн хангагдсан байна.



Эх сурвалж: YCX-1212.mn

1.43. “МУТХҮБ-2030”-ын Дэд бүтцийн салбарын зорилт 3-ын I үе шат (2016-2020), ЗГҮАХ-т тусгасан дараах арга хэмжээ 2020 онд хэрэгжээгүй байна.

- “...Ухаа худаг–Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглах, Богд хаан төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх...”, “Тавантолгой–Гашуун сухайт, Хөөт–Бичигт, Тавантолгой–Гашуун сухайт–Оюутолгойн, Шивээ хүрэн–Сэхэ, чиглэлийн төмөр замыг барьж дуусгана. Зүүнбаян–Ханги, Богд Хан төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.” арга хэмжээг үндсэн чиглэлд тусгаагүйгээс урт болон дунд хугацааны зорилт хангагдаагүй байна.
- “...Эрдэнэт–Овоот чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх...”, ЗГҮАХ-т “Эрдэнэт–Овоот чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ” арга хэмжээ нь Үндсэн чиглэл 7.4. “Эрдэнэт – Овоот чиглэлийн 547.7 км төмөр замын төслийн ажил”-д тусгаагдаж батлагдсан ч тухайн чиглэлийн төмөр замын трасст Тэсийн гол, Булнайн нурууны байгалийн цогцолборт газар, Ханжаргалант уулын байгалийн нөөц газар орсон нь арга хэмжээ хэрэгжихгүй байх нөхцөл үүсгэсэн байна.

1.44. Тухайн төсөл арга хэмжээний хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй байхад хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг барилга угсралтын ажлын түвшинд төлөвлөснөөс зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг хангаагүй байна. Тухайлбал:

- (6.1): Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх; (ЭХЯ)
- (6.1.3). Хоёрдугаар дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 300 МВт-аар өргөтгөх барилгын ажлын явц, хувиар /10%/
 - (6.1.4). Гуравдугаар дулааны цахилгаан станцын өндөр даралтын хэсгийн суурилагдсан хүчин чадлыг 75 МВт-аар өргөтгөх барилгын ажлын явц, хувиар /30%/
 - (6.1.6). Амгалангийн дулааны станцыг 50 МВт-ын дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэх станц болгон өргөтгөх барилгын ажлын явц, хувиар /30%/
- (6.2). Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, өмнөд бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах шинэ эх үүсвэр барих; (ЭХЯ)
- (6.2.3). Баруун бүсэд 60 МВт-ын дулааны цахилгаан станц барих төслийн барилгын ажлын явц, хувиар /20%/

(6.4). Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлэх; (ЭХЯ)

- (6.4.4). Улаанбаатар хот орчимд 100 МВт хүчин чадалтай усан цэнэгт цахилгаан станцын барилгын ажлын явц, хувиар /10%/

(7.2). Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, олон улсын 4С зэрэглэлд хүргэх; (ЗТХЯ)

(7.2). Ховд, Хөвсгөл, Дорнод аймгийн нисэх буудлыг өргөжүүлэх ажлын явц, хувиар /70%/

1.45. Үндсэн чиглэлд тусгагдсан ХХААХҮЯ, УУХҮЯ, ЭХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх зарим арга хэмжээний хэрэгжилтийн явцад хэрэгжүүлэгч байгууллагын зохион байгуулалт, хяналт хангалтгүйгээс үр дүнтэй нь холбож хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаагүй, батлагдсан хөрөнгийн хэмжээгээр тайлагнасан нь бодит бус байна. Тухайлбал:

- 3.2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо, сая, толгой ХХААХҮЯ-аас улсын төсвийн хөрөнгөөр 10.6 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлсэн, Сангийн яам батлагдсан 28.9 тэрбум төгрөгөөр тайлагнаж, 18.1 тэрбум төгрөгөөр зөрүүтэй, бодит бус тайлагнасан. (ХХААХҮЯ)
- 3.3. “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах явцыг 30 хувьд хүргэхээс хэдэн хувьд хүргэсэн талаар бүрэн тайлагнаагүй байна. (ХХААХҮЯ)
- 4.1. “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг ХХААХҮЯ-аас 969.9 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон гэж тайлагнасан, Сангийн яам зарцуулсан хөрөнгийг тайлагнаагүй. (ХХААХҮЯ)
- 4.5. Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах арга хэмжээнд ХХААХҮЯ-аас 7.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарсныг хэрэгжилтийн тайланд тус яам болон Сангийн яамнаас 7.3 тэрбум төгрөгөөр тайлагнаж алдаа гаргасан. (ХХААХҮЯ)
- 5.1. “Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх” арга хэмжээнд УУХҮЯ-аас 16.1 тэрбум төгрөг зарцуулсан байхад, УУХҮЯ, Сангийн яам нь батлагдсан 17.6 тэрбум төгрөгөөр тайлагнаж, 1.5 тэрбум төгрөгөөр зөрүүтэй, бодит бус тайлагнасан. (УУХҮЯ)
- 5.2. Уул уурхайн салбарын томоохон төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх “Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар” арга хэмжээнд 2020 онд 900 сая ам.долларын хувийн хөрөнгө оруулалт хийж, 2,564.9 тэрбум²⁰ төгрөгийн гүйцэтгэлтэй /Монголбанкнаас зарласан 2020.12.31-ны өдрийн ханш 1 ам.доллар 2849.89 төгрөгөөр тооцсон/ гарч, УУХҮЯ, Сангийн яам нь батлагдсан 2.740.0 тэрбум төгрөгөөр тайлагнаж, 175.1 тэрбум төгрөгөөр зөрүүтэй, бодит бус тайлагнасан. (УУХҮЯ)
- 5.3. Эдийн засгийн өсөлтийг дэмжих хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар” УУХҮЯ-аас хөгжлийн банкны санхүүжилтээр 20.9 тэрбум төгрөг зарцуулсан гэж тайлагнасан, УУХҮЯ, Сангийн яам нь батлагдсан 500.0 тэрбум төгрөг гадаад эх үүсвэрээр тайлагнаж, 479.1 тэрбум төгрөгөөр зөрүүтэй, бодит бус тайлагнасан. (УУХҮЯ)


²⁰ Монголбанкнаас зарласан 2020.12.31-ны өдрийн ханш 1 ам.доллар 2849.89 төгрөгөөр тооцоход

БҮЛЭГ 2. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОН ЗАСАГЛАЛ, ЭРХЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ 82.5 ХУВЬ БАЙНА.

Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчин, Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх болон Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого бодлогын хүрээнд нийт 13 зорилт 88 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас эрчимжүүлэх шаардлагатай 8, үр дүнгүй 9 арга хэмжээ байгаа бөгөөд үр дүнтэй бүрэн хэрэгжсэн 54, тодорхой үр дүнд хүрсэн 17 байна. /хэвсрэлт 5./

Дүрслэл 21.

2.1. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогод “МУТХҮБ-2030”-аас 14, ЗГҮАХ-өөс 27, Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого 1, Төрөөс ойн талаар баримтлах бодлого 1, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө 1, Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4, бусад салбарын бодлого 3, нийт 51 зорилт, арга хэмжээ бодлогын баримт бичиг, хөтөлбөрт тусгагдсан байна.



Эх сурвалж: УАГ

2.2. БОАЖЯ, БХБЯ, ОБЕГ, ҮХГ-аас нийт 38 зорилт, арга хэмжээ хэрэгжүүлэх саналыг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлснээс 3 зорилтын хүрээнд 22 арга хэмжээ батлагдсан байна. Хүснэгтээр үзүүлбэл:

“Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого”-ын зорилт, арга хэмжээний нэгдсэн судалгаа

Хүснэгт 15.

Яам, агентлаг	Төсөл				Баталсан		
	арга хэмжээ	шалгуур үзүүлэлт	санхүүжих дүн		арга хэмжээ	шалгуур үзүүлэлт	санхүүжих дүн
			сая.ам доллар	тэрбум төгрөг			
БОАЖЯ	6	13	-	236.5	5	13	93.1
БХБЯ	16	22	307.9	345.9	14	21	942.0
ОБЕГ	6	13	-	205.3	2	2	10.0
ҮХГ	10	12	-	0.52	1	1	-
Дүн	38	60	307.9	788.2	22	37	1,045.1

Эх сурвалж: Яам, агентлагаас хүргүүлсэн санал, УИХ-ын 2019 оны 54 дүгээр тогтоолын хэвсрэлт

2.3. Үндсэн чиглэлд тусгагдсан зарим арга хэмжээний хүрэх түвшинг дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөөгүйгээс хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчим хангагдахгүй, зорилтот түвшин биелэхгүй байх үр дагаврыг үүсгэж байна. /хэвсрэлт 6./

2.4. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын дараах зорилт, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн хуулийн 12.2²¹, 18 дугаар

²¹ 12.2.Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн холбогдох заалт, зорилт, арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусгасан байна.

зүйлийн 18.1²², 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан “судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх” зарчимд тус тус нийцүүлэн төлөвлөөгүйгээс бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн шаардлага хангаагүй байна. Тухайлбал:

Төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусгаагүй зорилт, арга хэмжээ:

(9.4) Хүн амын ундны болон ахуйн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг хийж, бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах, булаг, шандын эхийг хашиж хамгаалах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх “Шинээр байгуулах хөв, цөөрөм байгуулах болон булаг, шандын эхийг хамгаалах”; (БОАЖЯ)

(10.1) “Гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх аврах салбар, бүлгийн чадавхыг бэхжүүлэх”; (ОБЕГ)

Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын зарим зорилт, арга хэмжээний санхүүжилт батлагдаагүйгээс хугацаандаа бүрэн хэрэгжээгүй байна.

2.5. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын 3 зорилт 22 арга хэмжээг БОАЖЯ, БХБЯ, ОБЕГ дангаар болон бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн бөгөөд үр дүнтэй бүрэн хэрэгжсэн 10, тодорхой үр дүнд хүрсэн 4, эрчимжүүлэх шаардлагатай 5, үр дүнгүй 3 арга хэмжээ байна.

Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын хэрэгжилт (зорилт тус бүрээр)

Хүснэгт 16.

Бодлогын зорилтын нэр	Эрчимжүүлэх шаардлагатай (31-69)	Үр дүнгүй (0-30)
Байгалийн нөөц баялаг, дэд бүтцийн онцлогт тулгуурлан хүн амын нутагшил, суурьшил, хот суурины оновчтой тогтолцоог бий болгож, иргэдийн аюулгүй ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх	3	2
Агаар, орчны бохирдлыг бууруулан, экосистемийн тэнцвэрт байдлыг хангаж, аялал жуулчлалыг хөгжүүлэх	1	1
Гамшгаас хамгаалах мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, гамшгийн үеийн бэлэн байдлын түвшинг дээшлүүлэх	1	-

Эх сурвалж: УАГ

2.6. Бодлогын зарим арга хэмжээний төсөв батлагдаагүй, төсвийн тодотголоор санхүүжилт хасагдсан, хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдаагүй, COVID-19 цар тахлын нөхцөл байдал, үйл ажиллагааны зохион байгуулалт, хяналт хангалтгүйгээс бүрэн хэрэгжээгүй, зорилтод үр дүнд хүрээгүй байна. Тухайлбал:

- (9.1) “Агаар, орчны бохирдлыг бууруулах” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд төлөвлөгдсөн Хөтөлбөрийн Зорилт 1-ийн 4.1.6, 4.1.10, 4.2.17, 4.5.1 дахь ажлууд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт болон “Ковид-19” цар тахал дотоодод тархаж бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнээс шалтгаалан он дамжин гүйцэтгэхээр төлөвлөгдсөн байна. (БОАЖЯ)
- (9.2) Ой хамгаалал, ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг чанаржуулан ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд “Ойжуулалт, нөхөн сэргээлтийг 12000 га талбайд хийх”-ээр үндсэн чиглэлд тусгагдсан боловч санхүүжилт бүрэн батлагдаагүйн улмаас 1260 га талбайг ойжуулах, ойн нөхөн сэргээлт, ойн зурвас байгуулахаар төлөвлөж, 240 га талбайд хийх ойжуулалтын санхүүжилт 2020 оны төсвийн тодотголоор хасагдсанаас төлөвлөсөн арга хэмжээ дутуу хэрэгжсэн (БОАЖЯ)
- (9.4) Хүн амын ундны болон ахуйн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг хийж, бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах, булаг, шандын эхийг хашиж хамгаалах арга хэмжээний хүрээнд хүн амын унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох 5-аас доошгүй хайгуул судалгааны ажил хийхээс 1 судалгааны ажил гүйцэтгэж /Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр/, шинээр 3-аас доошгүй хөв, цөөрөм байгуулахаас Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд 1 хөв цөөрөм байгуулж /улсын төсвөөс 2 хөв цөөрөм байгуулах ажлын санхүүжилт батлагдаагүй/, шинээр хийх гидрогеологийн зураглалын

²² 18.1.Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна.

/1:200000 масштаб/ ажил улсын төсөвт санхүүжилт батлагдаагүйн улмаас хэрэгжээгүй, зорилтот үр дүнд хүрээгүй. (БОАЖЯ)

- (8.2.1) Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажилд шаардагдах санхүүжилтийн саналыг 2020 оны төсвийн тухай хуульд 87 тэрбум төгрөгөөр хүргүүлсэн ч батлагдаагүйн улмаас зорилтот түвшинд хэрэгжээгүй байна. Уг ажлыг хэрэгжүүлэх судалгаа хийгдэж, бэлтгэл хангагдсан байна. **/Нууцын зэрэглэлтэй/ (БХБЯ)**
- (8.2.2) Монгол Улсын геодезийн сүлжээний эхлэл цэгийг байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийг шийдвэрлээгүйгээс 2020 онд уг ажил үр дүнгүй болсон байна. (БХБЯ)
- (8.2.3) Шинээр байгуулах GNSS (GPS)-ийн байнгын ажиллагаатай суурин станц байгуулах ажлын хүрээнд 7 станц байгуулахаар төлөвлөсөн ч санхүүжилт батлагдаагүйн улмаас арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон байна. Шинээр суурин станц байгуулах бэлтгэл ажил буюу байнгын ажиллагаатай 35 станц холбох эрхтэй программ худалдан авч, хэрэглээнд нэвтрүүлэх ажил хийгдсэн байна. (БХБЯ)
- (8.2.5) Өндрийн II ангийн сүлжээний хайгуул судалгаа, давтан хэмжилт хийх ажлын хүрээнд нийт 3400 км урт шугамд хайгуул судалгаа, давтан хэмжилт хийхээр төлөвлөсөн ч санхүүжилт батлагдаагүйн улмаас төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна. (БХБЯ)
- (8.7) Дотоодын гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх; (БХБЯ)
- (8.9) Цементийн экспортын хэмжээг өмнөх оны үзүүлэлтээс 10 хувиар дээшлүүлэх зорилт тавьсан ч тайлант оны гүйцэтгэл 1,400,000 тонн цемент үйлдвэрлэж, 2020 онд дэвшүүлсэн хүрэх түвшинд огт хүрээгүй буюу өмнөх оны гүйцэтгэл /1,476,000 тонн/-д хүрээгүй байна. (БХБЯ)

2.7. Дунд хугацааны бодлогын баримт бичгийн зорилтод түвшинд хүрээгүй буюу хэрэгжилт дутуу дараах арга хэмжээ байна. Тухайлбал:

- (8.1) “МУ-ын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах арга хэмжээний хэрэгжилт үндсэн чиглэлийн биелэлтийг хангасан ч ЗГҮАХ -т тусгагдсан “хөгжлийн ерөнхий төслийг боловсруулан батлуулах” зорилтод түвшинд хүрээгүй байна. (БХБЯ)
- (8.2.1) МУ-ын нийт нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах арга хэмжээний хүрээнд 45 хувийг зурагжуулсан нь ЗГҮАХ -т тусгагдсан “МУ-ын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах” зорилтод түвшинд хүрээгүй байна. (БХБЯ)
- (8.2.2) МУ-ын геодезийн сүлжээний эхлэл цэгийг байгуулах арга хэмжээний хүрээнд байгуулах газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, талбайн хэмжээ, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицлыг баталсан нь нь ЗГҮАХ -т тусгагдсан “эхлэл цэгийг байгуулж, ОХУ, БНХАУ-ын сүлжээтэй холбох” зорилтод түвшинд хүрээгүй байна. (БХБЯ)
- (8.3) Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээний хүрээнд уг ажил 70 хувийн хэрэгжилттэй байгаа нь ЗГҮАХ -т тусгагдсан “геопортал байгуулагдах” зорилтод түвшинд хүрээгүй байна. (БХБЯ)
- (8.12) “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл”-ийг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт үндсэн чиглэлийн биелэлтийг хангасан ч ЗГҮАХ -т тусгагдсан “цэвэрлэх байгууламжуудыг өргөтгөн шинэчлэх, шинээр барих, туршилт тохируулга, зүгшрүүлэлт хийж, үйл ажиллагаа жигдрэх” зорилтод түвшинд хүрээгүй байна. (БХБЯ)

Бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тоо баримт, судалгаа шинжилгээнд үндэслэн үнэлж, дүгнээгүй, үнэн зөв, бүрэн тайлагнаагүй байна.

2.8. Үндсэн чиглэлд батлагдсан арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- (9.3) Биологийн олон янз байдлын тухай болон цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2020 онд 12 арга хэмжээнээс 9 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаагүй. (БОАЖЯ)
- (9.5) Аялал жуулчлалын дэд бүтэц, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажлыг бүрэн тайлагнаагүй. (БОАЖЯ)

2.9. Хэрэгжүүлэгч байгууллага, нэгжээс зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн, үнэн зөв тайлагнаагүй байхад ТЕЗ-ийн хяналт, шинжилгээ-үнэлгээний нэгж нь үнэлгээ, тоо баримт, судалгаа, шинжилгээнд²³ үндэслэлгүй ирүүлсэн тайлангийн хэмжээнд үнэлж, дүгнэж байгаагаас ТЕЗ, СЯ болон ЗГХЭГ-ын үнэлгээгээр үнэн зөв, бодитой дүгнэгдээгүй байна. Тухайлбал:

- (9.1) Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо хариуцан хэрэгжүүлж, хөтөлбөрийн 5 зорилт 58 арга хэмжээг 77.3 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гэвч хөтөлбөрийн Зорилт 1-ийн 4.1.6, 4.1.10, 4.2.17, 4.5.1, Зорилт 2-ын 4.2.7 дахь ажлыг он дамжин гүйцэтгэхээр төлөвлөж, 58.3 тэрбум төгрөгийг зарцуулан хөтөлбөрийн хэрэгжилтийг 75.5 хувиар үнэлэн тайлагнасан байхад ТЕЗ, Сангийн яам, ЗГХЭГ-аас 90 хувиар үнэлж, дүгнэсэн. (БОАЖЯ)
- (9.4) Хүн амын ундны болон ахуйн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг хийж, бороо, цасны усыг хуримтлуулах, хөв цөөрөм байгуулах, булаг шандын эхийг хашиж хамгаалах арга хэмжээний хүрээнд “Хүн амын унд, ахуйн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох” хайгуул, судалгааны 5 доошгүй ажил хийхээр тусгагдсан байна. Гэвч “Майдар хот төсөл”-ийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох 1 судалгаа хийж, төлөвлөсөн ажлын 20 хувийг гүйцэтгэсэн байхад ТЕЗ-аас 50 хувиар үнэлсэн. (БОАЖЯ)
- (8.2.6) Газар зүйн нэр, хаяг, геодезийн цэг тэмдэгт, хилийн цэсийн мэдээллийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд “нэгдсэн сүлжээний цахим системд хилийн цэс категори үүсгэн, үйлчилгээг нэвтрүүлсэн” гэх боловч тусгай категори үүсээгүй, иргэд үйлчилгээ авахад ойлгомжгүй мөн хаягийн мэдээллийн санд өгөгдөл мэдээлэл оруулж баталгаажуулах болон шинээр үүссэн суурьшлын хаягийн мэдээллийн сан бүрдүүлэх, баталгаажуулах ажлууд бүрэн хийгдэж дуусаагүй байхад ТЕЗ 100 хувийн биелэлттэй гэж үнэлсэн байна. (БХБЯ)
- (8.4) МУ-ын газар нутгийг газар ашиглалтын зориулалтаар нь тооллого явуулах, мэдээллийн санд бүртгэх ажлын хүрээнд зөрчилтэй нэгж талбарын мэдээллийг мэдээллийн санд бүртгэх ажил бүрэн хийгдэж дуусаагүй буюу МУ-ын нийт нутаг дэвсгэрийг бүрэн хамруулах зорилтод түвшинд хүрээгүй байхад ТЕЗ, СЯ, ЗГХЭГ 100 хувийн биелэлттэй гэж үнэлсэн байна. /Нууцын зэрэглэлтэй/ (БХБЯ)
- (8.14) Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг дэвшилтэт технологиор шинэчлэх ажлын хүрээнд барилга угсралтын ажлыг 30 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч ковид-19 цар тахлын улмаас гадаадаас ажиллах хүч оруулж ирэх хязгаарлагдмал нөхцөл байдалтай холбоотойгоор барилга угсралтын ажил удааширч, 15 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. Уг ажлыг ТЕЗ, СЯ, ЗГХЭГ үнэлэхдээ бүрэн хэрэгжсэн буюу 100 хувь гэж дүгнэсэн байна. (БХБЯ)

2.10. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээг төсөв захирагчид бодит гүйцэтгэлээс зөрүүтэй дүнгээр тайлагнасан байна. Тухайлбал:

БХБЯ

- (8.1)-д “МУ-ын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах ажлын хүрээнд улсын төсвөөс 1.1 тэрбум төгрөг зарцуулсан байхад Сангийн яам 2.8 тэрбумаар тайлагнасан байна.
- (8.2.4)-д “Газар зүйн нэрийн тодруулалтыг хийх” ажилд хөрөнгө зарцуулагдаагүй байхад Сангийн яам улсын төсвөөс 0.2 тэрбумаар тайлагнасан байна.
- (8.2.5)-д “Өндрийн II дугаар ангийн сүлжээний хайгуул судалгаа, давтан хэмжилт хийх” ажилд хөрөнгө зарцуулагдаагүй байхад Сангийн яам улсын төсвөөс 0.1 тэрбумаар тайлагнасан байна.
- (8.2.6)-д “Газар зүйн нэр, хаяг, геодезийн цэг тэмдэгт, хилийн цэсийн мэдээллийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх” ажилд хөрөнгө зарцуулагдаагүй байхад Сангийн яам улсын төсвөөс 1.2 тэрбум төгрөгөөр тайлагнасан байна.
- (8.3)-д “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” ажлын хүрээнд улсын төсвөөс 0.9 тэрбум төгрөг зарцуулсан байхад Сангийн яам 1.3 тэрбумаар тайлагнасан байна.
- (8.4)-д “Монгол Улсын газар нутгийг газар ашиглалтын зориулалтаар нь тооллого явуулах, мэдээллийн санд бүртгэх” ажлын хүрээнд улсын төсвөөс 0.9 тэрбум төгрөг зарцуулсан байхад Сангийн яам 1.0 тэрбумаар тайлагнасан байна.

²³ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.1.3

- (8.5)-д “Газрын төлөвлөлт, бүртгэл, бирж, үнэлгээ, мониторингийн нэгдсэн тогтолцоог бий болгох” ажлын хүрээнд улсын төсвөөс 0.8 тэрбум төгрөг зарцуулсан байхад Сангийн яам 1.9 тэрбумаар тайлагнасан байна.
- (8.6)-д “Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх” ажилд хөрөнгө зарцуулагдаагүй байхад Сангийн яам улсын төсвөөс 0.1 тэрбумаар тайлагнасан байна.
- (8.11)-д “Дархан хотын бохир усны менежментийн төсөл”-ийг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаад эх үүсвэрээс 6.4 тэрбум төгрөг зарцуулсан байхад Сангийн яам 17.7 тэрбумаар тайлагнасан байна.
- (8.12)-т “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл”-ийг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаад эх үүсвэрээс 22.8 тэрбум төгрөг зарцуулсан байхад Сангийн яам 63.9 тэрбумаар тайлагнасан байна.
- (8.14)-т “Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг дэвшилтэт технологиор шинэчлэх” ажлын хүрээнд гадаад эх үүсвэрээс 209.8 тэрбум, улсын төсвөөс 14.3 тэрбум төгрөг зарцуулсан байхад Сангийн яам 199.8 тэрбум, улсын төсвөөс 14 тэрбумаар тайлагнасан байна.
- (8.15)-д “Нийслэл, аймгийн төвийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил”-д улсын төсвөөс 73.1 тэрбум төгрөг зарцуулсан байхад Сангийн яам УТ-өөс 58.3 тэрбумаар тайлагнасан байна.

БОАЖЯ

- (9.1) Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд АБҮХ-оос 58.3 тэрбум төгрөг зарцуулсан байхад Сангийн яамнаас зарцуулсан хөрөнгийн дүнг тайлагнаагүй. (БОАЖЯ)
- (9.2) Ой хамгаалал, ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг чанаржуулан, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө захиран зарцуулсан байхад Сангийн яамнаас 0.7 тэрбум төгрөгийн хөрөнгө дутуу тайлагнасан.
- (9.3) Биологийн олон янз байдалд чухал ач холбогдол бүхий газруудад хамгааллын болон доройтлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 12 арга хэмжээ хэрэгжүүлж, 0.4 тэрбум төгрөг зарцуулсан байхад Сангийн яам, БОАЖЯ-аас дутуу тайлагнасан ажлын хүрээнд зарцуулсан хөрөнгийн дүнг тайлагнаагүй.
- (9.4) Хүн амын ундны болон ахуйн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг хийж, бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах, булаг, шандын эхийг хашиж хамгаалах арга хэмжээний хүрээнд 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө захиран зарцуулсан байхад Сангийн яамнаас 0.5 тэрбум төгрөгийн хөрөнгө илүү тайлагнасан.
- (10.1) Гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх аврах салбар, бүлгийн чадавхыг бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд 2.4 тэрбум төгрөг зарцуулсан байхад Сангийн яам 2.4 тэрбум төгрөгөөр илүү тайлагнасан.
- (10.2) Онцгой байдлын албаны техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах арга хэмжээний хүрээнд 260.2 тэрбум төгрөг зарцуулсан байхад Сангийн яам 122.5 тэрбум төгрөгөөр дутуу тайлагнасан.

Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлогын арга хэмжээг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн холбогдох заалт, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний үзүүлэлттэй уялдуулан төлөвлөх асуудал хангалтгүй байна.

Дүрслэл 22.

2.12. Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлогод “МУТХҮБ-2030”-аас 23, ЗГҮАХ-өөс 36, Гурван тулгуурт хөгжлийн бодлогоос 1, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогоос 7, Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлогоос 1, нийт 68 зорилт, арга хэмжээ бодлогын баримт бичиг, хөтөлбөр тусгагдсан байна



Эх сурвалж: ҮАГ

2.13. БСШУЯ, БОАЖЯ, ЭМЯ, ХНХЯ, ХХМТГ-аас нийт 59 зорилт, арга хэмжээ хэрэгжүүлэх саналыг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлснээс 37 зорилт, арга хэмжээ батлагдсан байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Зорилт, арга хэмжээний төлөвлөлтийн нэгдсэн судалгаа (тэрбум.төг)

Хүснэгт 17.

Яам, агентлаг	Төсөл			Баталсан		
	арга хэмжээ	шалгуур үзүүлэлт	санхүүжих дүн	арга хэмжээ	шалгуур үзүүлэлт	санхүүжих дүн
БСШУЯ	18	24	473.5	17	20	492.2
БОАЖЯ	-	-	-	1	2	8.0
ЭМЯ	10	33	449.4	7	19	321.0
ХНХЯ	15	16	1545.8	8	11	92.5
ХХМТГ	16	16	167.6	4	5	18.8
Нийт дүн	59	89	2636.3	37	57	932.5

Эх сурвалж: Яам, агентлагаас хүргүүлсэн санал, УИХ-ын 2019 оны 54 дүгээр тогтоолын хавсралт

2.14. Үндсэн чиглэлд тусгагдсан зарим арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөөгүй, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусгаагүйгээс бодлогын хэрэгжилт хангагдахгүй, зорилтот түвшин хугацаандаа биелэхгүй байхад нөлөөлжээ. Тухайлбал:

Төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусгаагүй зорилт, арга хэмжээ:

(12.2) “Ботаникийн цэцэрлэгийг тохижуулах, байгалийн ургамлын үндэсний генобанканд шаардлагатай барилгыг барих” (БОАЖЯ)

(12.6) Соёлын баримтат өвийг хамгаалах, музей, түүх, соёлын өвийн сэргээн засварлалтын ажлыг эрчимжүүлэх; (Соёлын яам)

(12.7) ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн бүртгэлд бүртгэгдсэн Монгол Улсын соёлын өвийг хамгаалах, Бурхан Халдун уулын соёлын өвийн менежментийн захиргааг байгуулах. (Соёлын яам)

(14.3) Төрөөс цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, цахим албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийг хөгжүүлэх; (ХХМТГ)

(14.4) Хиймэл дагуулын болон газрын сүлжээний радио давтамжийн автоматжуулсан систем нэвтрүүлэх; (ХХМТГ)

(16.3) Монгол залуусаа сургаж, дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадаас авах ажиллагчдын тоог бууруулах; (НХХЯ)

(16.5) Хүүхдийн хөгжил, хамгаалал, өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих бодлого хэрэгжүүлэх; (НХХЯ)

Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөөгүй, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусгаагүйгээс арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, зорилтод үр дүнд хүрээгүй байна.

2.15. Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлогын хүрээнд 6 зорилтын дагуу төлөвлөсөн нийт 37 арга хэмжээнээс үр дүнтэй буюу бүрэн хэрэгжсэн 22, тодорхой үр дүнд хүрсэн 7, эрчимжүүлэх шаардлагатай 3, үр дүнгүй 5 арга хэмжээ байна. Тухайлбал:

Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлогын эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй арга хэмжээний нэгтгэл

Хүснэгт 18.

Бодлогын зорилтын нэр	Эрчимжүүлэх шаардлагатай (31-69)	Үр дүнгүй (0-30)
Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	2	-
Соёл, урлаг, спортын үйлчилгээ, хүртээмж	1	2
Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэх, шинжлэх ухааны салбарыг өргөжүүлэх	-	1
Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	-	1
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, урьдчилан сэргийлэх	-	1


Эх сурвалж: УАГ

2.16. ЗГҮАХХАХТ-ний 3.2.59-д Үндэсний урлагийн Их театр шинээр байгуулах ажлын хүрээнд 2020 онд барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх, үндсэн чиглэлд “Үндэсний урлагийн Их театрыг бүрэн ашиглалтад оруулахаар тусгасан ч зорилтод түвшинг тооцоо судалгаагүй төлөвлөснөөс тус арга хэмжээ хэрэгжээгүй байна.

2.17. ЗГҮАХХАХТ-ний 3.2.43-т “Орчин үеийн музейн стандарт шаардлагыг хангасан Байгалийн түүхийн музейг шинээр барих” арга хэмжээг хэрэгжүүлэхдээ 2018-2020 онд барилгыг барьж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байна. Үндсэн чиглэлд “Орчин үеийн музейн стандарт шаардлагыг хангасан Байгалийн түүхийн музейг шинээр барих арга хэмжээ”-г тусгасан хэдий ч тендерийг БСШУЯ 2 удаа, ТХААГ 2 удаа тус тус зарласан ч амжилтгүй болж, гүйцэтгэгч шалгараагүйгээс тус арга хэмжээ хэрэгжээгүй байна.


Дүрслэл 23.

2.18. Үндсэн чиглэлийн 11.1-д “Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлэх” арга хэмжээний хүрээнд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 86 хувьд хүргэх, ЗГҮАХХАХТ-д “...Хүүхэд бүр цэцэрлэгт” гэж заасан ч 2020-2021 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 79.7 хувьтай байгаа нь зорилтот түвшинд хүрээгүй байна.



Дүрслэл 24.

2.19. МУТХҮБ-2030-д “...хоёроос ихгүй ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх”, ЗГҮАХ-т “2020 онд 3 ээлжийг 100 хувиар бууруулах” гэсэн зорилтыг дэвшүүлсэн ч Үндсэн чиглэлийн 11.2-д “Ерөнхий боловсролын сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, сурагчдын ая тухтай сурах орчныг бүрдүүлэх” арга хэмжээний хүрээнд шинээр 66 сургууль ашиглалтад оруулахаас 2019-2020 оны хичээлийн жилд 37 сургууль орж, нийт суралцагчдын 0.4 хувь буюу 2587 суралцагч 3 ээлжээр хичээллэж байгаа нь зорилтыг хангаагүй байна.



Эх сурвалж: YCX 1212.mn

Дүрслэл 25.

2.20. МУТХҮБ-2030-д “Нийгмийн түншлэл дээр үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, техникийн баазыг өргөжүүлж, суралцагчдын тоог 60.0 мянгад хүргэх” зорилт дэвшүүлсэн байхад үндсэн чиглэлийн 11.7-д зөвхөн “...мэргэжлийн боловсролын сургуулийн багшийг зөөврийн компьютертой болгох” зорилт дэвшүүлж бодлогын уялдааг хангаагүйгээс 2019-2020 оны хичээлийн жилийн байдлаар техникийн болон мэргэжлийн сургалтын байгууллагад 42.2 мянган суралцагчийг хамруулсан байна.



Эх сурвалж: YCX 1212.mn

2.21. Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлогын хүрээнд төлөвлөсөн зарим зорилт, арга хэмжээ тооцоолол судалгаанд үндэслээгүй, төсөв батлагдаагүй, хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдаагүй, COVID-19 цар тахлын нөхцөл байдал, үйл ажиллагааны зохион байгуулалт, хяналт хангалтгүйгээс бүрэн хэрэгжээгүй, зорилтот үр дүнд хүрээгүй байна. Тухайлбал:

Төсөвт санхүүжилт батлагдаагүй, төсвийн тодотголоор хасагдсан:

(11.3) Ердийн ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог, хэрэгцээнд тохирсон сургалтын орчин бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр мэргэшүүлэх сургалтад 60 багшийг хамруулах”; (БШУЯ)

(14.4) “Хиймэл дагуулын болон газрын сүлжээний радио давтамжийн автоматжуулсан систем нэвтрүүлэх”; (ХХМТГ)

(15.2) Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах арга хэмжээний хүрээнд “шинээр 6 хүүхдийн эмнэлэг ашиглалтад оруулах” (ЭМЯ)

(11.3) Ердийн ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог, хэрэгцээнд тохирсон сургалтын орчин бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн “Тохирох орчин бүрдүүлсэн 63 сургууль бүрдүүлэх”; (БШУЯ)

Хүрэх түвшин нь тооцоолол судалгаанд үндэслээгүй, бэлтгэл ажил хангагдаагүй, зохион байгуулалт, хяналт хангалтгүй:

(11.2) Ерөнхий боловсролын сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, сурагчдын ая тухтай сурах орчныг бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд стандарт хангасан ариун цэврийн байгууламжтай 46 дотуур байрыг нэмэгдүүлэхээр тусгагдсанаас 2019-2020 онд 30 дотуур байрыг нэмэгдүүлж, 22

дотуур байрны барилгын ажил 10-95 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж зорилт бүрэн хэрэгжээгүй. (БШУЯ)

(12.1) “Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх” арга хэмжээний хүрээнд 21 соёлын төв ашиглалтад оруулахаас Говь-Алтай аймгийн Бугат сум, Тонхил сум болон Баянхонгор, Галуут сумын Соёлын төвийн барилга, Архангай, Хотонт суманд баригдаж буй Солийн Данзангийн нэрэмжит музей, цэцэрлэгт хүрээлэн, Дорноговь, Сайншанд суманд кино театр зэрэг барилга тус тус ашиглалтад ороогүй. (Соёлын яам)

(12.1) Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2020 онд 15 спорт цогцолбор, ордон, заал, усан бассейн ашиглалтад оруулахаас 6 спорт заал, 1 усан бассейн ашиглалтад орж зорилт арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна. (БТСУХ)

(12.3) Үндэсний урлагийн Их театр шинээр байгуулах ажлын газрын зөвшөөрөл авах, барилгын зураг төслийг батлуулах, цэвэр бохир ус, холбооны техникийн болон цахилгаан дулааны техникийн нөхцөлүүдийн бэлтгэл ажил хангагдаагүйгээс барилга угсралтын ажил эхлээгүй. (Соёлын яам)

(16.1) Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 32274 иргэнийг хамруулах, 7367 байнгын 2540 түр ажлын байрыг бий болгох зорилт хэрэгжээгүй. (ХНХЯ)

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хөрш орны хил хаасан, бэлэн байдлын зэрэгт шилжсэн:

(15.6) “Эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх, МУ-д одоогоор оношлох, эмчлэх боломжгүй байгаа өвчнийг дотооддоо оношилж, эмчилдэг болох” арга хэмжээний хүрээнд гадаадын өндөр хөгжилтэй оронд 10 эмнэлгийн мэргэжилтнийг суралцуулах, гадаадад ажиллаж байсан мэргэжлийн ур чадвар бүхий 25 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эх орондоо ажиллуулах; (ЭМЯ)

(15.3) “Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа зүрх судас, хорт хавдар, бөөр түүнтэй холбоотой хүндрэлээс үүдэлтэй нас баралтыг бууруулах” арга хэмжээний хүрээнд “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх; (ЭМЯ)

(15.4) “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх” арга хэмжээний хүрээнд улирлын томуугүйн эсрэг вакцинжуулалтад нийт хүн амын 40 хувийг хамруулах, умайн хүзүүний хорт хавдрын вакциныг УБ хот болон 5 аймагт нэвтрүүлэх; (ЭМЯ)

(15.5) “Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх” арга хэмжээний хүрээнд 20 спорт клубийг магадлан итгэмжлэх; (ЭМЯ)

(15.7) “Эрүүл мэндийн салбарын дуусаагүй барилгуудыг ашиглалтад оруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах” арга хэмжээний хүрээнд шинээр 31 эмнэлгийг ашиглалтад оруулах; (ЭМЯ)

2.22. Үндсэн чиглэлийн дараах зорилт арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажлыг үнэн зөв тайлагнаагүй, тухайн ТЕЗ-ийн Хяналт, шинжилгээ-үнэлгээний нэгж нягтлан шалгахгүйгээр ирүүлсэн тайлангийн хэмжээнд үнэлж, дүгнэж байгаагаас СЯ болон ЗГХЭГ-ын үе шатны үнэлгээ үнэн зөв, бодитой үнэлэгдэхгүй байх үр дагаврыг үүсгэж байна.

(13.3) “Ботаникийн цэцэрлэгийг тохижуулах, байгалийн ургамлын үндэсний генобанканд шаардлагатай барилгыг барих” арга хэмжээний хүрээнд ажил хийгдээгүй байхад хамааралгүй ажил тайлагнасан. (БОАЖЯ)

(11.3) “Ердийн ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог, хэрэгцээнд тохирсон сургалтын орчин болон дэд бүтцийг бүрдүүлэх” арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр мэргэшүүлэх сургалтад 60 багш хамруулах” арга хэмжээг тайлагнахдаа багш нарын мэргэжил дээшлүүлсэн сургалтыг тайлагнасан. (БШУЯ)

Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогын арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүйгээс “Хил орчмын дэд бүтцийг хөгжүүлж, хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх” арга хэмжээ үр дүнгүй байна.

Дүрслэл 26.

2.23. Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогод “МУТХҮБ-2030”-аас 8, ЗГҮАХ-өөс 26, Гурван тулгуурт хөгжлийн бодлого 2, Статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 1, Гадаад бодлогын үзэл баримтлал 1, нийт бодлогын баримт бичгээс 38 зорилт, арга хэмжээ тусгагдсан байна.



Эх сурвалж: УАГ

2.24. Шадар сайдын ажлын алба, ХЗДХЯ, ГХЯ, БХЯ, ҮСХ, УЕПГ, СЕХ, СХЗГ, МХЕГ-аас нийт 90 зорилт, арга хэмжээ хэрэгжүүлэх саналыг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлснээс 29 зорилт, арга хэмжээ батлагдсан байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Зорилт, арга хэмжээний төлөвлөлтийн нэгдсэн судалгаа (тэрбум төгрөг)

Хүснэгт 19.

Яам, агентлаг	Төсөл			Баталсан		
	арга хэмжээ	шалгуур үзүүлэлт	санхүүжих дүн	арга хэмжээ	шалгуур үзүүлэлт	санхүүжих дүн
Шадар сайдын ажлын алба	-	-	-	1	1	-
ХЗДХЯ	16	16	123.0	16	16	66.9
ГХЯ	6	6	3.6	3	3	-
БХЯ	29	30	241.0	4	4	17.4
ҮСХ	21	21	9892.0	1	1	4.8
УЕПГ	-	-	-	1	1	-
СЕХ	-	-	-	1	1	-
СХЗГ	13	13	109.2	1	2	0.4
МХЕГ	5	5	17.2	1	2	2.4
Дүн	90	91	10386.0	29	31	92

Эх сурвалж: Яам, агентлагаас хүргүүлсэн санал, УИХ-ын 2019 оны 54 дүгээр тогтоолын хавсралт

2.25. Үндсэн чиглэлийн зарим арга хэмжээг тооцоо судалгаанд үндэслэх, хэрэгжих хугацааг хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилттэй уялдуулан төлөвлөх шаардлагатай байна. Тухайлбал:

(17.12) Визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх программ хангамжийг нэвтрүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн хэмжээг батлаагүй; (ХЗДХЯ)

(17.13) “ISM” системийн өргөтгөл, сайжруулалтын хүрээнд “APIS буюу APP” системийг холбож, мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжих боломжтой хугацааг үндэслэлтэй тооцоогүй (ХЗДХЯ)

(17.14) Гадаадын иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах баримт бичгүүдийн бүрдлийг цахим хэлбэрээр бүрдүүлэх боломж бүхий төрийн байгууллагуудын хооронд холбосон дэд бүтэц, системийг бий болгох арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн хэмжээг батлаагүй; (ХЗДХЯ)

(17.15) Их сургуулийн шинжлэх ухаан, инновацын чадавхыг нэмэгдүүлж, сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинжлэх ухаан, технологийн ололт, төрийн бодлоготой уялдуулан, багш судлаач, албан хаагч, сонсогчдын чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн хэмжээг батлаагүй; (ХЗДХЯ)

(17.19) Сонгуулийн санал тооллогын техник хэрэгслийг шинэчлэх арга хэмжээг авах” шаардагдах хөрөнгийн хэмжээг батлаагүй; (СЕХ)

Салбарын бодлогын хүрээнд 3 арга хэмжээний төсөв санхүүжилт батлагдаагүйгээс зорилтот түвшинд хүрээгүй байна.

2.26. Бодлогын зорилт, арга хэмжээнээс үр дүнтэй буюу бүрэн хэрэгжсэн 22, тодорхой үр дүнд хүрсэн 6, “Хил орчмын дэд бүтцийг хөгжүүлж, хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх” нэг арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй байна.Тухайлбал:

Төсөвт санхүүжилт батлагдаагүйгээс бүрэн хэрэгжээгүй:

(17.1) Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбоог шинэчилж, мэдээ, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэхэд 10,0 тэрбум төгрөгийн хөрөнгийг үндсэн чиглэлд баталсан боловч, улсын төсөвт хөрөнгийг тусгаагүй байна; (ХЗДХЯ)

(17.18) Прокурорын байгууллагын боловсон хүчний чадавхыг сайжруулах, барилга, конторын их засвар, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх арга хэмжээг улсын төсвийн 12 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр үндсэн чиглэлд тусгасан боловч улсын төсөвт 9.7 тэрбум төгрөг батлагдаж, төсвийн тодотголоор 4.5 тэрбум төгрөгийн төсөв хасагдсанаас шалтгаалж дутуу хэрэгжсэн байна. (УЕПГ)

(20.1) Зэвсэгт хүчний хээрийн хөдөлгөөнт холбооны зангилгааг шинэчлэх, хээрийн удирдлагын байруудад сансрын холбооны бага оврын станцуудыг суурилуулах арга хэмжээг тус яамны санал тайлбарт үндэслэн баталсан боловч санхүүжилт батлаагүйн улмаас дутуу хэрэгжсэн. (БХЯ)

2.27. Үндсэн чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлсэн тайланд зарим зорилт арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажил, хөрөнгийн зардлыг бүрэн, тодорхой тайлагнаагүй байна. Тухайлбал:

(17.13) “ISM” системийн өргөтгөл, сайжруулалтын хүрээнд “APIS буюу APP” системийг холбож, мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээний төсөв батлагдаагүй, улсын төсвөөс 48.0 сая төгрөг зарцуулсан боловч тайланд тусгаагүй. (ХЗДХЯ)

(18.1) МУ-ын үндэсний стандартыг шинээр боловсруулан баталж, орон нутгийн стандартын байгууллагын чадавхыг бэхжүүлэх арга хэмжээний Дорнод аймагт шинээр ашиглалтад орох барилгын санхүүжилтэд орон нутгийн төсвөөс 772,2 сая төгрөг зарцуулсныг тайланд тусгаагүй. (СХЗГ)

2.28. ҮСХ нь “Хүн ам, орон сууцны улсын тооллогыг явуулж, үр дүнд үндэслэн дэлгэрэнгүй судалгаа хийх, нийтэд тархаах” арга хэмжээний хүрээнд 12 судалгааг хийж гүйцэтгэхээс 9 төрлийн судалгааг гүйцэтгэж, аймаг бүрт тооллогын мэдээллийн тархалтын семинарыг зохион байгуулахаас 2 аймагт зохион байгуулж, бусад аймагт цар тахалтай холбогдуулан зохион байгуулаагүй байхад төсөв захирагчийн ХШҮДАГ-аас 95 хувиар үнэлсэн нь бодитой биш байна.

2.29. Шадар сайдын ажлын алба болон СЕХ-ны зохион байгуулалтын бүтцэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг бүхий нэгж, орон тоо байхгүйгээс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.4²⁴-д заасныг хэрэгжүүлээгүй.

²⁴ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хууль тогтоомжид заасан хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан, дүгнэлтийг Засгийн газар болон үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгагдсан нийт 127 зорилт, арга хэмжээнээс үр дүнтэй буюу бүрэн хэрэгжсэн 59, тодорхой үр дүнд хүрсэн 27, эрчимжүүлэх шаардлагатай 20, үр дүнгүй 21 арга хэмжээ буюу үндсэн чиглэлийн биелэлт дунджаар 73.2 хувьтай байна.
2. Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хүрээнд үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр тооцоолоогүй эрсдэл бий болох үед зохицуулалт хийж, бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ч тухайн жилийн зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.
3. Макро эдийн засгийн бодлогын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлэх, эдийн засгийн тогтвортой орчныг хангахад чиглэсэн зорилт, арга хэмжээ нь “Ковид-19” цар тахлын нөлөө, хэрэгжүүлэгч байгууллагын зохион байгуулалт хангалтгүй, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийхгүй байгаагаас 56.7 хувийн биелэлттэй байна.
4. Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлогын арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй, хөрөнгө батлагдаагүй, үйл ажиллагааны хяналт сул байгаагаас 53.7 хувийн биелэлттэй буюу зорилтот үр дүн хангагдаагүй байна.
5. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчин, Хүний хөгжлийг дэмжих нийгмийн, Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогуудад тусгагдсан зарим арга хэмжээний хүрэх түвшин, шаардагдах хөрөнгийг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөөгүй, судалгаа шинжилгээнд үндэслээгүй нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчим хангагдахгүй, зорилтот түвшин бүрэн биелэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, биелэлт 82.5 хувьтай байна.
6. Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт, зарцуулсан хөрөнгийг бодитой тайлагнах, тухайн ТЕЗ-ийн Хяналт, шинжилгээ-үнэлгээний нэгж болон Сангийн яам, ЗГХЭГ нягтлан шалгах, тайланг үнэлж, дүгнэх үе шатны үнэлгээг үнэн зөв бодитой тайлагнахад анхаарах хэрэгтэй байна.
7. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн үнэлгээ, ерөнхий хэрэгжилт сүүлийн 4 жилд 68.4-73.2 хувийн хэрэгжилттэй байгаа нь Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн хангалтгүй байгааатай холбоотой байна

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

1. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь цаашид УИХ-д өргөн мэдүүлж буй Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд бодлогын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газрын уялдаа холбоог хангах, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарал хандуулах;
2. Макро болон Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлогын хэрэгжилт сүүлийн 4 жилийн хугацаанд 59.4-53.7 хувийн биелэлттэй, үр дүн хангалтгүй байгаа нь цаашид дунд хугацааны II үе шатны зорилтот түвшин хангагдахгүй байх нөхцөлийг үүсгэж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй зорилт, арга хэмжээг хэрхэн үр нөлөөтэй болгох асуудлыг шийдвэрлэж, цаашид Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгахдаа төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй уялдуулан, хэрэгжилтийг бодитоор хангуулах үр дүнтэй ажлыг зохион байгуулах.
2. Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн үр дүн, хэрэгжилтийн үе шат бүрд үнэлгээ хийж, өмнөх жилүүдийн хэрэгжилт дутуу, хэрэгжээгүй арга хэмжээнд дүгнэлт хийж, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлого хангагдсан байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах.

Сангийн сайдад:

1. Төсөв захирагчдаас ирүүлж буй саналыг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг, төрөөс баримтлах салбарын бодлого, үндэсний хөтөлбөртэй уялдуулан хянаж, үндсэн чиглэлийн төсөлд тусгасан, тусгаагүй тухай үндэслэл, тайлбарыг төсөв захирагч нарт хүргүүлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах;
2. Цаашид Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, түүнд зарцуулсан хөрөнгийг бодитоор тайлагнаж, үнэлж байх.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах зорилт, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг цаашид оновчтой тодорхойлж, саналыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн боловсруулж хүргүүлэх;
2. Аудитын тайланд тусгагдсан зорилтот түвшин, үр дүн хангалтгүй, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан бүрэн хэрэгжүүлж, зарцуулсан хөрөнгө, санхүүжилтийг бодитой тайлагнаж, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээг хийхэд анхаарч ажиллах.

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад:

1. Цаашид Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн бодлого, төрөөс баримтлах салбарын бодлого болон үндэсний хөтөлбөртэй нийцүүлэн боловсруулах, санал, дүгнэлт өгөх чиг үүргээ хэрэгжүүлэх.
2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй зорилт арга хэмжээг цаашид Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй уялдуулан тусгаж, хэрэгжилтийг бүрэн хангуулах;

ЗГХЭГ-ААС ИРҮҮЛСЭН САНАЛ:



**МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

2021 он 04 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар ХТ/1157

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох тайлбарыг хүргүүлж байна.

Тайлбарт дурдсан мэдээллийг харгалзан үзэж Үндсэн чиглэлд заасан зарим арга хэмжээний гүйцэтгэлийг дахин хянан үзэх арга хэмжээ авна уу.

Хавсралт: ..2.. хуудастай.

Дэд дарга



У.БЯМБАСҮРЭН

007248

Үзүүлэлт	Ирүүлсэн санал, тайлбар
Тайлбар 1-ийг үзнэ үү.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүгнэлт хэсгийн 6 дугаарт “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн үнэлгээ, ерөнхий хэрэгжилт сүүлийн 4 жилд 68.4 хувиас 77.6 хувийн хэрэгжилттэй байхад Засгийн газраас зорилт, арга хэмжээг эрчимжүүлэх, хэрэгжилтийг өсгөхөд анхаарч ажиллаагүй байна” гэжээ. Монгол Улсын Засгийн газар “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт”-ийг хагас жил тутам хуралдаанаар хэлэлцэн биелэлт хангалтгүй байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлэх үүрэг, даалгаврыг холбогдох Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга нарт даалган ажиллаж байна. Тухайлбал: Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлд “биелэлт хангалтгүй 67 арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлж 2020 оны жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх”-ийг холбогдох Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга нарт даалгасан байна. Мөн танай газрын “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт”-д хийсэн жил бүрийн гүйцэтгэлийн аудитын тайланг яамдад хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна.
Тайлбар 2-ыг үзнэ үү.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн Хавсралт 1 дэх эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний судалгааны 20 дугаарт заасан арга хэмжээ болох “Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх” 46.5 хувиар үнэлснийг дахин нягталж үзнэ үү. Тус арга хэмжээ нь хоёр ажлаас бүрдэж байгаа бөгөөд нэгдүгээр ажил бүрэн хийгдсэн бөгөөд хоёрдугаар ажил нь тодорхой үр дүнд хүрч байгаа болно. Биелэлт: 2020 оны жилийн эцсийн байдлаар Дорноговь аймгийн Өргөн сумын, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын, Булган аймгийн Хангал сумын, Дорнод аймгийн Чулуунхороот сумын спорт заалны барилга, Завхан, аймгийн Улиастай сумын спорт цогцолборын барилга, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Усан бассейны барилга, Сайншанд сумын 1000 хүний суудалтай соёл, спортын цогцолбор, Улаанбадрах сумын соёл, спортын төвийн 200 хүний суудалтай барилга, Хөвсгөл сумын 200 хүний суудалтай соёл, спортын төвийн барилга, нийт 9 барилга тус тус ашиглалтад орсон байна. Мөн 70-90 хувийн гүйцэтгэлтэй 7 барилга, 50-69 хувийн гүйцэтгэлтэй 14 барилга, 30-49 хувийн гүйцэтгэлтэй 5 спорт цогцолбор, ордон, заал, усан бассейны барилга байна.
Тайлбар 3-ыг үзнэ үү.	Тайлангийн Хавсралт 2 дахь үр дүнгүй арга хэмжээний судалгааны 20 дугаарт заасан арга хэмжээ болох “Эмч эмнэлгийн мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх, Монгол Улсад одоогоор оношлох, эмчлэх боломжгүй байгаа өвчнийг дотооддоо оношилж, эмчилдэг болох”-ыг 0 хувиар үнэлснийг дахин нягталж үзнэ үү. Тус арга хэмжээ нь хоёр ажлаас бүрдэж байгаа бөгөөд нэгдүгээр ажлын хүрээнд тодорхой хэмжээний ажил хийгдсэн болно. Биелэлт: “Ковид-19” цар тахлын улмаас 2020 онд гадаад сургалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тулгарсан хэдий ч олон улсын мэргэжлийн чиглэлийн нийгэмлэг, холбоодын нэр хүнд бүхий алсын зайн, цахим, төлбөртэй сургалтуудад эмч, мэргэжилтнүүдээ өргөнөөр хамруулахыг зорьж ажилласан бөгөөд энэ хүрээнд дээрх олон улсын чанартай алсын зайн цахим, цуврал модуль бүхий сургалтад давхардсан тоогоор 349 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд Австри Улсын Засгийн газрын нөхцөлт зээлийн санхүүжилтээр төсөл хэрэгжиж байгаатай холбогдуулан төслийн хүрээнд Соронзон резонанст томографын аппарат /MRI 1.5Tesla/ дээр ажиллах 8 эмч, мэргэжилтнийг Австри Улсад 2020 оны эхний сард сургасан байна.

ҮАГ-ЫН ТАЙЛБАР:

ЗГХЭГ-аас ирүүлсэн 3 санал, тайлбарыг хүлээн авч, тайлангийн 1 заалтад нэмэлт тодруулга, найруулгын өөрчлөлт хийж, 2 тайлбарыг хүлээн авах боломжгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	Тайлангийн төслийн дүгнэлт ...“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн үнэлгээ, ерөнхий хэрэгжилт сүүлийн 4 жилд 68.4-73.2 хувийн хэрэгжилттэй байгаа нь Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн хангалтгүй байгаатай холбоотой байна....гэж нэмэлт тодруулга, найруулгын өөрчлөлт оруулав.
Тайлбар 2	Тайлангийн “Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний судалгаа”-ны 20 дугаарт заасан “Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх” арга хэмжээ 12.1.1-т ...“ <i>Шинээр ашиглалтад оруулах соёлын төв, музей, театрын тоо</i> ” арга хэмжээнд ирүүлсэн тайлбар нь нотлох баримтаар дэмжигдээгүй, 12.1.2-т ...“ <i>Шинээр ашиглалтад оруулах 15 спорт цогцолбор, ордон, заал, усан бассейн</i> ” арга хэмжээний 7 барилга байгууламж ашиглалтад орж, “Сайншанд сумын 1000 хүний суудалтай соёл, спортын цогцолбор”, “Улаанбадрах сумын соёл, спортын төвийн 200 хүний суудалтай барилга”, “Хөвсгөл сумын 200 хүний суудалтай соёл, спортын төвийн барилга” гэсэн 3 арга хэмжээ нь Соёлын яамны багцад хамрагдаж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 3	Тайлангийн “Үр дүнгүй арга хэмжээний судалгаа”-ны 20 дугаарт заасан “Эмч эмнэлгийн мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх, Монгол Улсад одоогоор оношлох, эмчлэх боломжгүй байгаа өвчнийг дотооддоо оношилж, эмчилдэг болох” арга хэмжээний тайлбар нь ТЕЗ-ийн Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланд тусгагдаагүй тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

САНГИЙН ЯАМНААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР:



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2021.04.28 № 5-2/2217
танай 2021.04.20-ны № 61/1254 -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧИЙН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.НАРАНЧИМЭГ
ТАНАА

Санал өгөх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Улсын Их Хурлын чуулганы 2020 оны 5 дугаар сарын 07-ны нэгдсэн хуралдаанаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлагдсан бөгөөд энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтад “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан төлөвлөсөн үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичгийг;”, 4.1.11 дэх заалтад “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг;” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрлийг хуульчилж өгсөн. Энэ хуулийг 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Мөн Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг батлан хэрэгжүүлж байна.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Тайлбар
1-ийг үзнэ
үү.

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас дэлхийн улс орнуудын эдийн засагт томоохон хүндрэл учирч, эдийн засаг унаж, хөгжлийн дунд хугацааны тооцоо, төсөөлөл өөрчлөгдсөн. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын тархалтаас сэргийлсэн хорио цээрийн дэглэмийн улмаас Монгол Улсын эдийн засаг огцом хумигдаж, -5.3 хувиар агшсан байна. Иймд тайлангийн төсөлд тусгагдсан цар тахлаас үүдэлтэй арга хэмжээнүүдийн хэрэгжилттэй холбоотой дүгнэлтүүдийг анхаарах;

9761004157

Тайлбар
2-ыг үзнэ
үү.

2. Үндсэн чиглэлд тусгагдсан 127-зорилт, арга хэмжээг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн хөрөнгийн хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэрийн боломжтой уялдуулан төлөвлөсөн бөгөөд эдгээр арга хэмжээний 77 арга хэмжээ нь “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-тай, 113 арга хэмжээ нь “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй, 28 арга хэмжээ нь салбарын Төрөөс баримтлах бодлоготой, 5 арга хэмжээ нь бусад бодлогын баримт бичгүүдтэй тус тус уялдсан тул тайлангийн төслийн “Ерөнхий мэдээлэл” хэсэгт тусгагдсан “Үндсэн чиглэлд тусгагдсан зарим зорилт, арга хэмжээг урт болон дунд хугацааны бодлогын зорилтуудтай уялдуулаагүй, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг бодитой тооцоо судалгаанд үндэслээгүй, хэрэгжилтийн явцад хариуцан хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хяналт хангалтгүйгээс арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.” гэсэн дүгнэлтийг дахин авч үзэх;

Тайлбар
3-ыг үзнэ
үү.

3. Тайлангийн төслийн 1.28-д “Үндсэн чиглэлийн төсөлд тусгуулахаар хүргүүлсэн нийт 22,967.2 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр нь Монгол Улсын 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэлд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн төсвийн зарлагын батлагдсан дээд хэмжээ 13,197.4 тэрбум төгрөгөөс 9,769.8 тэрбум төгрөг буюу 1.7 дахин их байгаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.517 -д заасан хязгаараас давсан байна.” гэж дүгнэсэн нь хүчингүй болсон хуулийн заалтыг үндэслэсэн байх тул хасах;

Тайлбар
4-ийг үзнэ
үү.

4. Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталж, Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлагдсан, мөн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсанаас хойш 3 жилийн дараа боловсруулагдсан, түүнчлэн үндсэн чиглэлд тусгасан тухайн арга хэмжээг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн хөрөнгийн хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэрийн боломжтой уялдуулан төлөвлөсөн тул тайлангийн төслийн 1.29 дэх дүгнэлтийг нягтлан үзэх;

Тайлбар
5-ыг үзнэ
үү.

5. Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, шалгуур үзүүлэлт, гарсан үр дүнд үндэслэж тайлагнадаг бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт тодруулгыг авч тусгадаг тул тайлангийн төсөл дэх “Бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тоо баримт, судалгаа шинжилгээнд үндэслэн үнэлж, дүгнээгүй, үнэн зөв, бүрэн тайлагнаагүй байна” дүгнэлтийг дахин авч үзэх;

Тайлбар
6-ааг үзнэ
үү.

6. Яамд, байгууллагууд Үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээний зарцуулсан хөрөнгийн хэмжээг тайлагнахдаа анх төлөвлөсөн хөрөнгийн хэмжээгээр тайлагнах асуудал гардаг тул тухай бүр тодруулга авч, нягтлан тусгадаг тул тайлангийн төслийн 2.10 дахь хэсгийг бүхэлд нь хасах;

Тайлбар
7-оог үзнэ
үү.

7. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ...Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотоо боловсруулна.” гэж заасан тул тайлангийн төсөл дэх Сангийн яаманд өгсөн 2 дахь зөвлөмжийг хасах зэрэг болно.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.НАРАНЦОГТ

Сангийн яамнаас ирүүлсэн 7 санал, тайлбарыг хүлээн авч, тайлангийн 6 заалтад нэмэлт тодруулга, найруулгын өөрчлөлт оруулж, 1 тайлбарыг хүлээн авах боломжгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	Тайлангийн төслийн 1.14-т тусгагдсан ...2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ий бодит өсөлт (-5.3) хувийн бууралттай гарсан нь дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр зорилтот үр дүнг хангаагүй байна... гэж нэмэлт тодруулга хийлээ.
Тайлбар 2	Тайлангийн төслийн Ерөнхий мэдээллийн ...Үндсэн чиглэлд тусгагдсан зарим зорилт, арга хэмжээг урт болон дунд хугацааны бодлогын зорилтуудтай бүрэн уялдуулаагүй, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг бодитой тооцоо судалгаанд үндэслээгүй, хэрэгжилтийн явцад хариуцан хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хяналт хангалтгүйгээс арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна... гэж нэмэлт тодруулга хийлээ.
Тайлбар 3	Тайлангийн төслийн 1.28-т тусгасан ...Үндсэн чиглэлийн төсөлд тусгуулахаар хүргүүлсэн нийт 22,744.3 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр нь тухайн ТЭЗ-ийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан 2020 оны төсвийн зарлагын дээд хэмжээ 1,747.1 тэрбум төгрөгөөс 20,185.9 тэрбум төгрөг буюу 7.9 дахин их байгаа нь тухайн үед мөрдөгдөж байсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.525-т заасан хязгаараас давсан байна.... гэж найруулгын өөрчлөлт хийлээ.
Тайлбар 4	Тайлангийн төслийн 1.29-т тусгасан ...“Эдийн засгийн бодлого”-ын зарим арга хэмжээний тайлант онд шаардагдах хөрөнгийн хэмжээ нь ЗГҮАХ-т тусгасан холбогдох заалтын 2020 оны төсвийн дүнгээс зөрүүтэй тусгасан байна... гэж найруулгын өөрчлөлт хийлээ.
Тайлбар 5	Тайлангийн төслийн ...Бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тоо баримт, судалгаа шинжилгээнд үндэслэн үнэлж, дүгнээгүй, үнэн зөв, бүрэн тайлагнаагүй байна...гэсэн дүгнэлт нь төсөв захирагчид, хяналт шинжилгээ үнэлгээ хийж буй байгууллага хамрагдаж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 6	Тайлангийн төслийн 2.10-т ...Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээг Сангийн яам нь бүрэн хянаагүй, бодит гүйцэтгэлээс зөрүүтэй дүнгээр тайлагнасан байна.... гэж нэмэлт тодруулга хийлээ.
Тайлбар 7	Тайлангийн төслийн Зөвлөмж ...Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй зорилт арга хэмжээг цаашид Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй уялдуулан тусгаж, хэрэгжилтийг бүрэн хангуулах... гэснийг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гэж нэмэлт тодруулга хийлээ.

²⁵ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтын нийт дүн нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан тухайн салбарын зарлагын дээд хязгаараас хэтрэхгүй байна.

Хавсралтууд:

Хавсралт1.

Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний судалгаа

№	Бодлого	Бодлогын баримтын дугаар	Арга хэмжээ	Үнэлгээ /хувь/	Хариуцах байгууллага
1	МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	1.2.	Татварын орчныг хялбар, энгийн, шударга болгож, бизнес эрхлэлтийг дэмжих	50	СЯ
2		1.3.	Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх	50	ХНХЯ
3		2.6.	Санхүүгийн салбарын өрсөлдөөн болон хүртээмжийг дэмжих, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, зохицуулалтыг боловсронгуй болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх	40	СЯ, СЗХ
4		2.7.	Банкнаас бусад санхүүгийн салбарт олгох тусгай зөвшөөрлийн тоог бууруулж, хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгах	50	СЗХ
5	ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО	3.3.	“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	50	ХХААХҮЯ
6		4.2.	Хүн амын эрүүл, аюулгүй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хангалтыг нэмэгдүүлэх	50	ХХААХҮЯ
7		4.3.	Үр тарианы талбайн хөрсний үржил шимийг сайжруулж, ургацын хэмжээг нэмэгдүүлэх, Атрын IV аяныг эхлүүлэх	63.2	ХХААХҮЯ
8		4.6.	“Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	33	ХХААХҮЯ
9		5.2.	Уул уурхайн салбарын томоохон төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	66	УУХҮЯ
10		5.4.	Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоог сайжруулж, Евро-5 стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх	40	УУХҮЯ
11		6.1.	Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх	42.5	ЭХЯ
12		6.6.	Аймгийн төвүүд болон томоохон хот суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	53	ЭХЯ
13	БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО	8.2.	Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох	56.1	БХБЯ
14		8.8.	Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх, гэр хороололд амины орон сууц барихад урт хугацааны хөнгөлөлттэй нөхцөлөөр ипотекийн зээл олгох	61	БХБЯ
15		8.14.	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг дэвшилтэт технологиор шинэчлэх	50	БХБЯ
16		9.4.	Хүн амын ундны болон ахуйн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг хийж, бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах, булаг, шандын эхийг хашиж хамгаалах	50	БОАЖЯ
17		10.1.	Гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх аврах салбар, бүлгийн чадавхыг бэхжүүлэх	50	ОБЕГ
18	ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЙГМИЙН БОДЛОГО	11.2.	Ерөнхий боловсролын сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, сурагчдын ая тухтай сурах орчныг бүрдүүлэх	60.3	БШУСЯ
19		11.3.	Ердийн ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог, хэрэгцээнд тохирсон сургалтын орчин болон дэд бүтцийг бүрдүүлэх	31.8	БШУСЯ
20		12.1.	Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх	46.5	Соёлын яам

Эх сурвалж:ҮАГ

Үр дүнгүй арга хэмжээний судалгаа

№	Бодлого	Бодлогын баримтын дугаар	Арга хэмжээ	Үнэлгээ /хувь/	Хариуцах байгууллага
1	МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	1.1.	Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй болон аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг хангах	0	СЯ
2		2.2.	Төсвийн алдагдлыг бууруулж, төсвийн тогтвортой байдлыг хангах	25	СЯ
3	ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО	4.4.	Жижиг, дунд үйлдвэр болон загвар хоршоодыг санхүү, зээлийн бодлогоор дэмжих	30	ХХААХҮЯ
4		4.5.	Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	30	ХХААХҮЯ
5		5.3.	Эдийн засгийн өсөлтийг дэмжих хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	12	УУХҮЯ
6		6.2.	Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, өмнөд бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах шинэ эх үүсвэр барих	27.5	ЭХЯ
7		6.3.	Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлэх	20	ЭХЯ
8		6.4.	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлэх	22	ЭХЯ
9		6.5.	Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг эхлүүлэх	26.7	ЭХЯ
10		7.2.	Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, олон улсын 4С зэрэглэлд хүргэх	30	ЗТХЯ
11		7.3.	Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэх	0	ЗТХЯ
12		7.4.	Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх	25	ЗТХЯ
13	БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО	8.7.	Дотоодын гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	30	БХБЯ
14		8.9.	Дотоодод үйлдвэрлэсэн цементийг экспортлох бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх	0	БХБЯ
15		9.5.	Аялал жуулчлалын дэд бүтэц, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх	0	БОАЖЯ
16	ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЙГМИЙН БОДЛОГО	12.2.	Орчин үеийн музейн стандарт шаардлагыг хангасан Байгалийн түүхийн музейг шинээр барих	30	Соёлын яам
17		12.3.	Үндэсний соёл урлагийг дэмжих хүрээнд Үндэсний урлагийн Их театр шинээр байгуулах		Соёлын яам
18		13.3	Ботаникийн цэцэрлэгийг тохижуулах, байгалийн ургамлын үндэсний генобанканд шаардлагатай барилгыг барих	0	БОАЖЯ
19		14.4.	Хиймэл дагуулын болон газрын сүлжээний радио давтамжийн автоматжуулсан систем нэвтрүүлэх	0	ХХМТГ
20		15.6.	Эмч эмнэлгийн мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх, Монгол Улсад одоогоор оношлох, эмчлэх боломжгүй байгаа өвчнийг дотооддоо оношилж, эмчилдэг болох	0	ЭМЯ
21	ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ	19.1.	Хөрш орнуудтай хийх гадаад худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх	0	Шадар сайд

Эх сурвалж: УАГ

Хавсралт 3.

Үндсэн чиглэлийн төсөлд Сангийн яамнаас нэмж тусгасан санал

№	арга хэмжээ дугаар	Зорилт, арга хэмжээний нэр	Шаардагдах хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/	Хөрөнгийн эх үүсвэр	Хариуцах байгууллага
1	3.4	Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүй, хариуцлагын тогтолцоо, бэлчээрийн менежментийг сайжруулах	6.7	Улсын төсөв	ХХААХҮЯ
2	4.3	Үр тарианы талбайн хөрсний үржил шимийг сайжруулж, ургацын хэмжээг нэмэгдүүлэх, Атрын IV аяныг эхлүүлэх	11.9	Улсын төсөв, Гадаад эх үүсвэр	
3	2.8	Үнэт цаасны төлбөр тооцооны программ хангамжийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх			СЗХ
4	8.8	Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх, гэр хороололд амины орон сууц барихад урт хугацааны хөнгөлөлттэй нөхцөлөөр ипотекийн зээл олгох	230	Улсын төсөв, бусад эх үүсвэр	БХБЯ
5	18.2	Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын чадавхыг бэхжүүлэх	2.4	Улсын төсөв	МХЕГ
6	15.1	Зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт эрт илрүүлгийн тогтолцоог бэхжүүлэх	28.6	Улсын төсөв, ЭМДС	ЭМЯ
7	15.7	Эрүүл мэндийн салбарын дуусаагүй барилгуудыг ашиглалтад оруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	62.7	Улсын төсөв	
8	19.1	Хөрш орнуудтай хийх гадаад худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх	0.2	Улсын төсөв	Шадар сайдын ажлын алба, ГХЯ
9	12.1	Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх	52.4	Улсын төсөв	БСШУСЯ
10	12.2	Орчин үеийн музейн стандарт шаардлагыг хангасан Байгалийн түүхийн музейг шинээр барих	100	Улсын төсөв	
11	12.3	Үндэсний соёл урлагийг дэмжих хүрээнд Үндэсний урлагийн Их театр шинээр байгуулах	100	Улсын төсөв	
12	12.4	Үндэсний бахархал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн түүхэн сэдэвтэй кино, бүтээл туурвихад төрөөс дэмжлэг үзүүлэх	1.5	Улсын төсөв	
13	12.5	Эх орноо төлөөлөн Токио-2020 олимпын наадамд оролцох баг, тамирчдын бэлтгэл, үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг, тусалцаа үзүүлэх	20	Улсын төсөв	
14	6.10	Шөнийн цагаар эрчим хүч хуримтлуулж, оргил ачааллын цагаар нийлүүлэх зориулалттай 50-100 хүртэлх МВт-ын том чадлын цэнэг хураагуурын систем барих төслийн бэлтгэл ажлыг хангах	-	-	ЭХЯ
Сангийн яам-аас нэмж тусгасан арга хэмжээний нийт дүн			616.2		

Эх сурвалж: ҮАГ

Хавсралт 4.

“Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай” хуулийн өөрчлөлтийн судалгаа

д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2019.05.30-ны хуулиар баталсан дүнгээс /зөрүү/ ТХМ-2020 он		2020.08.28-ны хуулиар	2019.11.13-ны хуулиар	2019.05.30-ны хуулиар
		Төсвийн Хүрээний мэдэгдэл				
		тоо	хувь	2020 он	2020 он	2020 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	-1		-1	6	6
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	-4.2	47.5	3.8	8	8
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	-	87.5	9,730.9	11,797.8	11,122.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1,391.7				
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.1	92.3	25.2	29	27.3
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	1,380.1	110.5	14,577.5	13,872.6	13,197.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	5.3	116.4	37.7	34.1	32.4
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	-	30.9	704.9	2,283.5	2,283.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1578.6				
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-3.8	32.1	1.8	5.6	5.6
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-	233.6	-4,846.6	-2,074.7	-2,074.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2,771.9				
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-7.4	245.1	-12.5	-5.1	-5.1
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	-398.0	89.5	3,408.0	3,806.1	3,806.1
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-0.6	93.6	8.8	9.4	9.4
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	1,976.7	108.9	24,065.8	22,089.1	22,089.1
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	7.9	114.5	62.2	54.3	54.3
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	893.6	218.1	1,650.2	756.6	756.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.4	226.3	4.3	1.9	1.9

Эх сурвалж: Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль

Хавсралт 5

Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчин, Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх болон Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогын хэрэгжилт

	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого	Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	Нийт
Үр дүнтэй буюу бүрэн хэрэгжсэн	10	22	22	54
Тодорхой үр дүнд хүрсэн 70-99	4	7	6	17
Эрчимжүүлэх шаардлагатай 31-69	5	3		8
Үр дүнгүй 0-30	3	5	1	9
Нийт	22	37	29	88

Эх сурвалж: УАГ

Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүйгээр Үндсэн чиглэлд тусгасан зорилт арга хэмжээний жагсаалт

Бодлогын баримт бичиг		Бодлогын баримт бичигтэй уялдаагүй зорилт, арга хэмжээ	
		Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээ	Нийцээгүй үзүүлэлт
Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр (төлөвлөгөө)	ЗГҮАХХАХТ-ний 2.79.3	(8.1) “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах	Хүрэх түвшин
	ЗГҮАХХАХТ-ний 2.81.3	(8.2.1) Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах	Хүрэх түвшин
	ЗГҮАХХАХТ-ний 2.81.8	(8.2.2) Монгол Улсын геодезийн сүлжээний эхлэл цэгийг байгуулах	Хүрэх түвшин
	ЗГҮАХХАХТ-ний 2.81.11	(8.3) Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх	Хүрэх түвшин
	ЗГҮАХХАХТ-ний 4.1.1.7	(8.6) Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хүрэх түвшин
	ЗГҮАХХАХТ-ний 2.91.2	(8.12) “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл”-ийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Хүрэх түвшин
	ЗГҮАХХАХТ-ний 4.2.7.2	(9.2) Ой хамгаалал, ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг чанаржуулан ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх	Хүрэх түвшин
	ЗГҮАХ-ийн 3.2.2.1 дэх заалт	(11.1) Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлэх	Хүрэх түвшин
	ЗГҮАХ-ийн 4.1, 4.3 дэх заалт	(13.3) Ботаникийн цэцэрлэгийг тохижуулах, байгалийн ургамлын үндэсний генобанканд шаардлагатай барилгыг барих	Бодлогын уялдаагүй
	ЗГҮАХ-ийн 3.2.47, 3.2.49, 3.2.53, 3.2.54 дэх заалт	(12.1) Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд шинээр спорт цогцолбор, заал, усан бассейн ашиглалтад оруулах	
	ЗГҮАХ-ийн 3.2.20 дахь заалт	(11.6) Хөдөө орон нутгийн их, дээд сургууль, салбар сургуулиуд түүнд элсэгчдийг дэмжих	
	ЗГҮАХ-ын 3.2.10 дахь заалт	(11.7) Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын сургуулийн багшийг зөөврийн компьютертой болгох	
	ЗГҮАХ-ийн 3.2.44, 3.2.47 дахь заалт	(12.7) ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн бүртгэлд бүртгэгдсэн Монгол Улсын соёлын өвийг хамгаалах, Бурхан Халдун уулын соёлын өвийн менежментийн захиргааг байгуулах	
	ЗГҮАХ-ийн 3.2.3, 3.2.6 дахь заалт	(11.2) Ерөнхий боловсролын сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, сурагчдын ая тухтай сурах орчныг бүрдүүлэх	Шалгуур үзүүлэлт
	ЗГҮАХ-ийн 3.2.10 дахь заалт	(11.4) Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх	
Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5	(8.1) “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах	Хүрэх түвшин
	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 2,	(11.2) Ерөнхий боловсролын сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, сурагчдын ая тухтай сурах орчныг бүрдүүлэх	Шалгуур үзүүлэлт
		(11.6) Хөдөө орон нутгийн их, дээд сургууль, салбар сургуулиуд түүнд элсэгчдийг дэмжих	Бодлогын уялдаагүй
Төрөөс баримтлах салбарын бодлогын баримт бичиг	Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын 4.3.3	(8.14) Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг дэвшилтэт технологиор шинэчлэх	Хүрэх түвшин
Гурван тулгуурт хөгжлийн бодлого		(11.2) Ерөнхий боловсролын сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, сурагчдын ая тухтай сурах орчныг бүрдүүлэх	Шалгуур үзүүлэлт
		(11.6) Хөдөө орон нутгийн их, дээд сургууль, салбар сургуулиуд түүнд элсэгчдийг дэмжих	Бодлогын уялдаагүй

Эх сурвалж: УАГ